

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**

ЗОРИЛТ	Сумын ЗДҮАХ- ийн арга хэмжээний тоо	Хийгдээгүй Үнэлэх боломжгүй ажил	ХЭРЭГЖИЛТ
НЭГ. ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД	20	1	98.42%
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД	7	0	95.71%
ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД	42	1	97.80%
ДӨРӨВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД	26	0	98.84%
ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, УУЛ УУРХАЙН ХҮРЭЭНД	12	0	90%
ЗУРГАА. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД	12	4	81.25%
Дүн	119	6	93,67%

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	ЗДҮАХөтөлбөрийн заалт	Хэрэгжилт	Хувь
ЗОРИЛТ 1.НЭГ.ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД			
Зорилго: Төрийн үйлчилгээг зөв зохион байгуулан, хариуцлагатай, чадварлаг төрийн албыг төлөвшүүлж, нээлттэй,ил тод байдлыг ханган, хуулийг хэрэгжүүлэн ажиллана.			
1.1.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах			
1	1.1.1 Сумын боловсон хүчний нөөцийн судалгааг гарган, төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллуулна.	Сумын засаг даргын зөвлөлийн хурлаар Хүний нөөцийн бодлого,төлөвлөгөөг хэлэлцэн, засаг даргын 2017 оны А/113 тоот захирамжаар батлууллаа. Сумын хэмжээнд одоогийн байдлаар мэргэжилтэй /дээд,тусгай дунд /314 иргэний судалгаа гарлаа.Үүнээс: Төвийн багт 189, хөдөөгийн багт 125Баг бүр иргэдийг ажилд зуучлахад хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаж,судалгаанд тодотгол хийж байна.Төсөвт байгууллагуудын нягтлан, бичиг хэргийн ажилтнууд 605 төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хуулийн хугацаанд гарган цахимд байршууллаа.	100
2	1.1.2 Төрийн албан хаагчдыг чадваржуулах ажлыг зохион байгуулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, ил тод хүртээмжтэй хүргэнэ.	Энэ онд нийт давхардсан тоогоор 28 мэргэжилтэн төвлөрсөн сургалтанд хамрагдлаа.Улаанбаатар хотод харьяа байгууллагуудын удирдлагууд Удирдлагын академид “Удирдлагын манлайлал” , 7 цэцэрлэгийн арга зүйч Хүүхдийн хөгжлийг үнэлэх арга зүйн сургалтанд, байгууллагын нягтлан бодогч нар санхүүгийн мэдээ гүйцэтгэлийн тайлагналт , шилэн дансны хуулийн тухай -15, Аймгийн БСУГ- аас зохион байгуулсан цөм хөтөлбөрийн сургалтанд 126 багш 3 удаа /давхардсан тоо/, 42 туслах багш 1 удаа хамрагдаж, онол дадлагын мэдлэгээ дээшлүүлээ. Сургууль цэцэрлэгүүд улирал бүр үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаанд 986 иргэдийг хамруулж 90-98%-тай үнэлэгдлээ.Сумын төсөвт байгууллагуудын үйлчилгээний албан хаагчдын дунд Дэлхийн зөн ОНХХ-тэй хамтран сургалт, тэмцээн зохион байгууллаа. Сургалтанд 12 байгууллагын 54 жижүүр, үйлчлэгч оролцож сургалт мэдээлэл хийлээ. “Сүүн цагаан- Сайнцагаан” сониноор дамжуулан 128 мэдээллийн иргэдэд хүргэлээ.Dundgovi.gov.mn сайтад -101, Сайнцагаан ЗДТГазар / fag/ хуудсанд- 204, , АСЦогцолбор FM-107.5 –аар 8 удаа мэргэжилтэн, Лед дэлгэцээр 15,Урсдаг самбар 16, багийн засаг дарга нар үйл ажиллагааны мэдээлэл нийт 447 мэдээллийг иргэдэд түгээлээ.	100

3	1.1.3Төрийн албан хаагчдыг гадаад дотоодод туршлага судлуулах, мэргэшүүлэх,сургалтанд хамруулах боломжийг нэмэгдүүлнэ.	Ерөнхий боловсролын сургуулиуд Дорноговь аймаг , Говьсүмбэр аймаг , Нийслэлийн 84, 20, ”Эрдмийн өргөө” зэрэг сургуулиудад 92 багш ажилчид туршлага судаллаа. Цэцэрлэгүүд аймаг ,сумын засаг дарга , БСУГ, Дэлхийн зөн ОНХХ-ийн дэмжлэгтэйгээр Эрээн хот, ОХУ Улаанбаатар хот, бусад аймгийн нийт 44 цэцэрлэгийн үйл ажиллагаатай 150 гаруй багш ажилчид харилцан туршлага судаллаа. Сумын ЗДТГазрын 30 албан хаагчид Дорноговь аймгийн Сайншанд сумын ЗДТГазар,Хот тохижилтын газрын үйл ажиллагаатай танилцаж, Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ЗДТГазрын албан хаагчидтай ярилцлага зохион байгууллаа.ДЗОУБ-тай хамтран эрүүл мэндийн төвийн 3 эмч Улаанбаатар хотод , Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс зохион байгуулсан сургалтанд ЭМТөвийн 2 их эмч , Эмнэл зүйн тойрон сургалтын 5 хоногоор 3 их эмч эх барих эмэгтэйчүүд , мэдрэл, хүүхдийн чиглэлээр туршлага судлаж сургалтанд хамрагдлаа. Хүүхдийн өвчний үед хэрэглэх шинэ эмийн сургалт, элэгний С вирусын эмийн танилцуулгад 5 эмч нийт 8 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 21 эмч мэргэжилтэн хамрагдлаа .	100
4	1.1.4Малчдыг мэдээллээр хангах, тэднийг төрийн үйл ажиллагаанд оролцох боломжийг нэмэгдүүлж, явуулын үйлчилгээг улирал бүр хүргэнэ	Хөдөөгийн багууд багийн хурал цуглааныг улирал бүр хийж, / Наран баг 4 удаа– 18, Тэвш баг 3 удаа 16, Далай баг 5 удаа 15 , Үйзэн баг 3 удаа 16 / 65 асуудлыг шийдвэрлэж, 1048 иргэнийг хамрууллаа.Сумын засаг даргын А/82 тоот захирамжаар хөдөөгийн багуудад ажиллалаа. Уг ажлын хүрээнд удирдлагууд, багийн засаг дарга нар,хүн эмнэлэг ,мал эмнэлэг , орон нутгийн цаг үеийн мэдээлэл хийэ, 18 удаа 1212 өрхөд /давхардсан тоогоор/ төрийн үйлчилгээг хүргэлээ.	100
5	1.1.5.Нутгийн захиргааны байгууллагаас бодлого боловсруулах, шийдвэр гаргахад иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлж, төрийн зарим чиг үүргийг ТББ-уудаар гүйцэтгүүлнэ.	Төвийн 5 баг албан тоот- 1010, тодорхойлолт- 1540, тогтоол- 18, захирамж -4, удирдамж -12, мэдэгдэл -28, хөдөөгийн багууд БИНХурлаараа нийт 21 тогтоол тус тус гаргасан байна. Дэлхийн зөн ОНХХ-тэй хамтран Хүүхдэд ээлтэй дотуур байр хөтөлбөрийн хүрээнд дотуур байрны 186 сурагчдад харилцаа хандлага , зөв дадал хэвшилд сургах ,Хүүхэд хамгаалал , Гэр бүлийн хүчирхийллийн тухай-157 Жирэмсэн эхчүүдийн сургалтанд гэр бүлийн гишүүний хамтаар 40 иргэн , Баг, сургуулийн нийгмийн ажилтнуудад Кейс менежмент -10, Төрийн үйлчилгээний албан хаагчдын сургалт-54 , Жаргалтай гэр бүл аянд 40 өрхийн 80 иргэн , Эмэгтэйчүүд эрүүл бол үндэстэн эрүүл зэрэг сургалтанд 40 иргэнийг тус тус хамруулан нийт 700 гаруй албан хаагч иргэн , сурагч оролцлоо.	100
6	1.1.6 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ ХАА-нд орон нутгийн иргэд, ААНэгжийг оролцуулах, ”Шилэн тендер”ийн бодлого хэрэгжүүлнэ	Энэ онд бараа ажил үйлчилгээ худалдан авах ажлыг зохион байгуулах үнэлгээний хороонд ажиллах АЗ сертфитикатын сургалтанд 30 иргэн суралцсанаас 28 иргэн амжилттай суралцан төгссөн өнгөрсөн оноос 21 хүнээр өссөн байна.Энэ онд үнэлгээний хороо 18 байгуулагдсан, тендерийн талаарх мэдээллийг Дундговь вэб сайт, Сүүн цагаан- Сайнцагаан сонин , сумын вэб сайтаар олон нийтэд хүргэлээ. Улсын төсвөөс 601,264,700 төгрөг, ОНХСангаас 129442,7 мянган төгрөг зарцуулаад байна.Тендерт 60 гаруй ААНэгж, байгууллага оролцлоо.	100
7	1.1.7Төрийн албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, хариуцлагыг нэмэгдүүлж, хариуцсан ажлын мэдлэг,чадварыг сайжруулна.	Тамгын газрын даргын тушаалаар ажлын байрны тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ,нийт 39 албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлууллаа. Байгууллагуудын жижүүрийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр 11 төсөвт байгууллага бүрэн камержиж хяналтын системийг захирал, эрхлэгч жижүүрийн өрөөнд суурилууллаа. Харуул хамгаалалтын ажилтнуудын дунд зохион байгуулсан 10 хоногийн сургалтанд 25 жижүүр хамрагдаж мэргэжлийн үнэмлэхтэй боллоо. Ажлын байрны тодорхойлолтын дагуу ажиллалаа. Сумын ЗДТГ-ын 26 , байгууллагын удирдлагууд , бичиг хэргийн 21 ажилчдаас Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн	100

		хуулиар тест боловсруулан шалгалт авч дүгнэж нийтлэг алдаа дутагдлыг ярилцлаа	
1.2.Хууль ёсыг бэхжүүлж,иргэдийн оролцоог нэмэгдүүлэх			
8	1.2.1 Захиргааны ерөнхий хуулийг албан хаагч бүр хариуцсан ажилдаа хэрэгжүүлж, шийдвэр гаргахад иргэдийг оролцуулан,тэдний эрхийг хамгаална.	Захиргааны ерөнхий хууль, зөрчлийн тухай хуулиар харьяа байгууллагын удирдлагууд болон албан хаагчиддаа сургалтыг зохион байгууллаа. Одоогийн байдлаар засаг дарга 3 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна. Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төрийн албан хаагчийн заавал судлах хуулийн жагсаалтын дагуу төсөвт байгууллагуудын удирдлагууд сургалтыг явууллаа. Сумын засаг дарга энэ онд А захирамж 226, Б захирамж 10 –ыг гаргасан байна. Улирал бүр захирамжийг хянуулж зөвлөмжийг хэрэгжүүллээ.	100
9	1.2.2 ”Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.	Сумын эрхзүйн хөтөч багийн хүрээнд багийн засаг дарга нар ГХУСэргийлэх зөвлөлтэй хамтран Гэмт хэрэг зөрчилгүй аюулгүй амар тайван орчин аяны хүрээнд болзолт уралдаан , тэмцээнүүдийг иргэд, ТАХ-ийн дунд хамтран зохион байгуулж 400 гаруй иргэнд хууль эрхзүйн мэдлэгийг нэмэгдүүллээ. Далай багийн малчдын дунд багийн өдөрлөг зохион байгуулж 150 гаруй иргэн оролцож , Замын хөдөлгөөн , Хулгайн гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг сурталчиллаа. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх аяны хүрээнд Лед дэлгэцээр олон нийтэд тус хуулийг сурталчилан, байгууллагуудад сургалт зохион байгуулж, ЕБС-ийн сурагчдын дунд эссэ бичлэгийн уралдаан зарлан шилдэг 10 эссэ шалгарууллаа. “Хамтдаа шийдье” арга хэмжээг хуваарийн дагуу явуулж, хөдөөгийн 4 багийн нэгдсэн хурлаар 101 малчинд Бодь даатгал, малын индексжүүлсэн даатгал , Төвийн багуудын өдөрлөг зохион байгуулж 272 иргэнд мэдээлэл өглөө. Авилгын эсрэг олон улсын өдрийг тохилдуулан төсөвт байгууллагуудын нийт 5 багийн 25 удирдах албан тушаалтны дунд “Элсэн цаг” хуулийн тэмцээнийг ХЭХэлтэс,Элгэмсэг дотно Дундговь ТББайгууллагатай хамтран зохион байгууллаа. Төвийн багуудын өдөрлөгийг хуваарийн дагуу зохион байгуулж , ИТХ-ын дарга, ЗДарга, мэргэжилтнүүд иргэдэд цаг үеийн , хууль эрх зүйн, цаашид орон нутагт хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл хийлээ. Нийт 1272 иргэн оролцлоо.	100
10	1.2.3. Иргэдийн оролцоотой Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, бүх шатанд авлигаас ангид ,ашиг сонирхлын зөрчилгүй ил тод байдлыг хангана.	Сумын 2017 оны Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж ЗД-ын А/29 тоот захирамжаар баталж, цахим хуудас, самбарт байрлуулж сурталчиллаа.Авилгатай тэмцэх газрын ажлын хэсгийн шалгалтанд амжилттай дүн үзүүллээ. ХАСХОМ гаргагч 22 албан хаагчийн мэдүүлгийг цахимд байршуулж баталгааны маягтыг гаргууллаа. Мандал сургууль, ГИЦСургуулийн сургалтын менежерээр томилогдохоор Э.Мөнхзул, Б.Болдбаатар,байгаль орчны хяналтын улсын байцаагч Ж.Миеэсүрэн,багийн 9 багийн засаг дарга,сумын засаг даргын орлогчийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газарт хянуулж ,хуулийн хугацаанд томилгоог хийлгэж, ХАСХОМ-ийг хугацаанд нь цахимд бүртгэлээ.	100
11	1.2.4. Байгууллага бүрийн архивын баримтын хадгалалт хамгаалалтыг стандартын шаардлагад нийцүүлж , эрэлт хайлт , тоо бүртгэл мэдээллийн цахим сан байгуулна.	Сумын ЗТГазар, ХТГ-ын А, Б захирамж , А, Б тушаал бүхий 6 хадгаламжийн нэгжийг скайнардэж цахим санд бүрдүүллээ.Байгууллага бүр албан бичгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд 7 цэцэрлэг , 4 сургууль 2016 оны тушаалаа архивлан , цахим сан бүрдүүлж сумын архивын цахим санг бүрдүүлж байна. Байгууллагын удирдлагууд, бичиг хэргийн ажилтнуудад, багийн засаг дарга,нийгмийн ажилтнуудад бичиг хэргийн стандартын талаар зөвлөгөө, зааварчилгааг тогтмол өгч албан бичгийн стандартын мөрдөн ажиллалаа. Харьяа байгууллагын удирдлагуудын 2017 онд гаргасан тушаалыг хянаж	100

		зөвлөмж хүргүүлээ.	
12	1.2.5.Мэргэжлийн байгууллагатай хамтран иргэдийн оршин суух хаягийн мэдээллийн зөрчлийг арилгана.	Баг хооронд хүүхэд-233, том хүн-190, иргэний шилжилт хөдөлгөөнийг хийж, нийт 423, 16 настай-226, 25 настай-314, 45 настай-173 , иргэний бичиг баримтаа үрэгдүүлсэн-214 нийт 927 иргэнд цахим үнэмлэх олгож, хаягийн зөрчил арилгах ажлыг зохион байгууллаа. 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 15508 хүн амтай боллоо. Харьяа байгууллагын төрийн албан хаагчдыг хаягийн зөрчилгүй болгох арга хэмжээг хэрэгжүүлээ.	100
13	1.2.6“Хамтдаа шийдье”арга хэмжээг зохион байгуулна.	“Хамтдаа шийдье” арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа. Сар бүр тодорхой салбарын иргэдийн төлөөлөлтэй хэлэлцүүлэг хийлээ.“Хамтдаа шийдье” арга хэмжээг Ахмадууд, сургууль, багийн нийгмийн ажилтнуудтай , Хамтын ажиллагаа түншлэлийн жилийн хүрээнд төр хувийн хэвшлийн уулзалтыг зохион байгуулж , Газар тариалан эрхлэгч , Төрийн үйлчилгээний албан хаагчдын сургалт ,ХБИ-ийн уулзалт, СХСангаас зээл авсан иргэдийн сургалт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж сумын удирдлагууд, мэргэжилтэн нар сум орон нутгийн цаг үеийн мэдээллийг танилцуулж , цаашид хэрхэн хамтран ажиллах , тулгамдаж буй асуудал , тэдний санал хүсэлтийг нь сонслоо. Арга хэмжээнд 900 гаруй иргэн оролцлоо.	100
1.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх			
14	1.3.1 ГХУСэргийлэх ажилд иргэд, төрийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна.	Олон нийтийн эргүүлийн хуваарийг Засаг даргаар батлуулан, 2 сарын хугацаанд төсвийн 15 байгууллагын 60 ажилчин, архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг 47 аж ахуй нэгжийн 119 ажилчдыг гудамж талбайд эргүүлийн үүрэг гүйцэтгүүллээ. Мөн согтууруулах ундаагаар үйлчилдэг 49 байгууллагын хуваарь гарган эргүүлд гаргалаа.Цагдаагийн газартай хамтран байгууллагуудын жижүүрийн үйл ажиллагаанд хяналт тавин зөвлөмжийн дагуу ажиллалаа. Сумын ЗДТГазраас үйлчилгээний албан хаагчдын төрийн албаны ёс зүй , үйлчилгээний албан хаагчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх сургалтанд төсөвт байгууллагуудын 23 жижүүр хамрагдлаа.	100
15	1.3.2“Архигүй Дундговь” хөтөлбөрийг хэрэгжүүлж, архидалтгүй орчин бүрдүүлэхэд иргэдийн хяналт,үйл ажиллагааг дэмжинэ.	Багийн засаг дарга нар АА-ын хамааралтай 61 иргэний судалгаа гаргалаа. Үүнээс 35 иргэн сургалтанд хамрагдаж 8 иргэн архинаас татгалзсан, иргэний судалгааг гарган бүртгэл хяналтанд авлаа. “Дэлхийн Зөн” ОНХХ, Цагдаагийн газартай хамтран ”Жаргалтай гэр бүл” 2 сарын аяны хүрээнд зорилтот өрхийн 40 иргэнийг гэр бүлийн хамтаар 8 модуль сургалтанд, сумын ЭМТөвтэй хамтран эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрууллаа. Цагдаагийн газраас ирсэн албан мэдэгдлийн дагуу 4 гэр бүлтэй багийн нийгмийн ажилтнууд ажиллаж нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өглөө. ААнийгэмлэгтэй хамтран Өөрчлөлтийг өөрөөсөө сургалтанд 37 , Говийн хийморь ААнийгэмлэгийн ойн арга хэмжээ , сургалтанд 10 иргэнийг хамрууллаа. АА-ын цуглаан хийх байраар ханган үйл ажиллагааг дэмжлээ. Хорихоос өөр төрлийн ялтай 10 иргэнийг орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцууллаа. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй 54 аж ахуй нэгжийн хүнсний дэлгүүр, зоогийн газар, зочид буудлын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийлээ.Хяналт шалгалтаар батлагдсан үнэлгээний хуудсаар дүгнэхээс гадна, 2015-2016 онд архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар арга хэмжээ авсан зөрчлийн судалгааг харгалзан үнэлгээ өглөө. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хяналт шалгалтын нэгдсэн хурлыг зохион байгуулж, 14 дэлгүүрийн архи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг цуцлуулах саналыг аймгийн засаг даргад хүргүүлснээр зөвшөөрлийг цуцалсан байна.	70

16	1.3.3Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ,хүүхдийг гэмт хэрэг,осол зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, эцэг,эх,асран хамгаалагчийг татан оролцуулж, үүрэг хариуцлагыг сайжруулна.	Сургуулийн нийгмийн ажилтнууд Өсвөрийн цагдаа бүлгэмийн хүүхдүүд, Хүүхдийн байцаагчтай хамтран Замын осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эхчүүд, сурагчид, жолооч, багш ажилчдад сургалт ,сурталчилгааны ажлыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгууллаа. Сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “school police” эцэг эхийн эргүүлийг тогтмол гаргаж байна. Энэ онд аймгийн төвийн авто замд явган хүний гарцын 15 тэмдэг, тэмдэглэгээг байршуулж, 2,500,000 төгрөг зарцууллаа.Дэлхийн зөн ОНХХ, Цагдаагийн газартай хамтран бага насны хүүхдийг замын хөдөлгөөнд аюулгүй оролцох хамгаалалт бүхий ханцуйвчийг 1-5-р ангийн 1752 сурагчдад олголоо. Сурагчид замын хөдөлгөөнд оролцохдоо ханцуйвчийг хэрэглэж хэвшсэнээрээ замын осол аюулаас өөрийгөө сэргийлэх чухал ач холбогдолтойг тайлбарласан яриа таниулгыг Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч ахмад Жавзандулам хийлээ. Зам тээврийн осолд хүүхэд өртөж байгаа шалтгаан нь жолооч нар машин согтуугаар барих, утсаар ярьж анхаарлаа сарниулах, хурдтай явах зэргээс хүүхэд хохирч байгааг анхааруулсан нөлөөллийн үйл ажиллагаа Тэмүүлэл СОУЗ-ийн сурагчид зохион байгуулж, ЭДЦС-ийн зүүн замаар зорчигч 30 жолоочид анхааруулга санамжийг уншууллаа.	100
17	1.3.4 Сумын цагдаагийн төлөөлөгч, цагдаагийн байцаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, иргэдэд шуурхай үйлчилгээ хүргэх боломжийг нэмэгдүүлнэ.	Цагдаагийн кабоны засварт 151.900төгрөгийн дэмжлэг үзүүллээ.Цагдаагийн байцаагч , төлөөлөгч багийн нийгмийн ажилтнуудтай хамтран Жаргалтай гэр бүл аян , Хот тохижуулах газар, байгаль орчны байцаагчтай хамтран орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд хорихоос өөр төрлийн ялтай 10 иргэнд сургалт зохион байгуулж ,модны нүх ухах ажил, сургууль төгсөгчдийн Эрдмийн баяр , Хүүхдийн баярын Дугуйн уралдааныг хамтран зохион байгууллаа. Тусгай зөвшөөрөлтэй ААНэгжүүдэд хяналт шалгалт хийхэд тогтмол хамтран ажиллалаа. Сумын ЗДТГазраас цагдаагийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд 205 л шатахуун , бичгийн цаас 3 боодлыг олгоод байна. Цагдаагийн байцаагч Д.Цэвэлмааг сумын засаг даргын “Жуух”аар шагналаа.Зарим үйл ажиллагаанд хамтран ажиллалаа.	100
18	1.3.5Мал сүргийг хамгаалах, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ,урьдчилан сэргийлэхэд чиглэсэн малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжинэ.	Сумын ГХУСЗөвлөл, БИНХурлын дарга нар хөдөөгийн 4 багийн малын хулгайтай тэмцэх бүлэглэлтэй хамтран ажиллаж , ГХУСЗөвлөл Далай багийн нутагт Гэмт хэрэг зөрчилгүй аюулгүй орчин аяны хүрээнд өдөрлөг зохион байгуулж, малын хулгайн талаар мэдээлэл хийлээ. Өдөрлөгт 150 гаруй малчин иргэд оролцлоо. Дэрэн суманд болсон малын хулгайтай тэмцэх зүүн бүсийн зөвлөгөөнд 8 малчин оролцууллаа. Далай багт малын хулгайтай тэмцэх 3 нөхөрлөл байдаг.Сумын хэмжээнд Тэвш багийн нутаг “Ихэрийн хөндий”-д малын хулгайн 1тохиолдол гарч , гэмт хэргийг бүрэн илрүүлж хохирогчийг хохиролгүй болголоо. Хэргийг илрүүлэх, таслан зогсооход цагдаагийн төлөөлөгчтэй хамтран ажилласаны үр дүнд гэмт хэрэг илэрсэн нь цаашид малын хулгайн гэмт хэрэг гарахгүй байх нөхцөл бүрдлээ.	100
1.4.Батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх			
19	1.4.1Батлан хамгаалах хууль тогтоомжийг иргэдэд сурталчилан хэрэгжүүлж, хяналт тавина.	Цэрэг татлагыг 2 удаа явуулж, цэргийн насны нийт 355 иргэдийг хамрууллаа. Цэргийн жинхэнэ албанд 25 цэрэг тэнцлээ. Ихэнх цэргийн насны залуус өвнөөр чөлөөлөгдөж байна.Цэргийн насны 300 гаруй залууст цагдаагийн хэсгийн байцаагчтай хамтран “Зөрчлийн тухай хуулиар сургалт мэдээлэл хийлээ. Харьяа байгууллагын цэргийн насны эрэгтэйчүүдийн судалгааг гаргууллаа.Судалгаанаас үзвэл цэргийн насны иргэдийн 30 % нь цэргийн жинхэнэ алба хаасан иргэд байна.	100

20	1.4.2.Дайчилгааны нөөцийн бүрэлдэхүүний сургалтанд иргэдийг хамруулна.	Дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтанд цэргийн штабаас ирүүлсэн хяналтын тооны дагуу иргэдийг хамрууллаа.	100
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД			
<i>Зорилго: Эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, “Шилэн данс”ны хуулийг бүх шатанд хэрэгжүүлнэ.</i>			
2.1.Эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх			
1	2.1.1.Суманд ашиглалтгүй байгаа төрийн өмчийн барилгын тоог гарган эдийн засгийн эргэлтэнд оруулах, хөрөнгөөс хасах ажлыг хуулийн дагуу зохион байгуулна.	-Сумын Засаг даргын 2017 оны А/61 тоот захирамжаар суманд ашиглалтгүй байгаа үндсэн хөрөнгийн тоог гаргах ажлын хэсэг байгуулагдаж ,харъяа төсөвт байгууллагуудад ажиллалаа. Судалгааны үр дүнд ашиглалтгүй болон илүүдэлтэй хөрөнгийн жагсаалт байгууллага тус бүрээр гаргуулан сумын ИТХУралд актлах саналыг албан ёсоор хүргүүллээ.	100
2	2.1.2. Хотын ерөнхий төлөвлөгөөг шинэчилж батлуулна.	Аймгийн ИТХ-хурлаар хэлэлцүүлж, 22 тоот тогтоол гарлаа. Хотын ерөнхий төлөвлөгөөг хүлээн авах ажлын комисс байгуулагдлаа.	100
3	2.1.3.Банк болон бусад байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлж,уялдаа холбоог сайжруулна.	Төрийн банктай хамтран бодлогын хүү, цалингийн зээлийн хүүгийн өөрчлөлтийн талаар ярилцлага зохион байгууллаа. Ярилцлагад 48 албан хаагч оролцлоо. Хас банк , Төрийн банктай хамтран Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Дугуйн уралдаан, Бүтэн өнчин хүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнүүдийг хамтран зохион байгуулж 480000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ.“Хамтын ажиллагаа-түншлэл”-ийн жилийн хүрээнд “Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа” хэлэлцүүлэгийг төрийн байгууллага,ААНэгжийн захирал, иргэний төлөөллийг хамруулан /50/ СЭЗДСургууль, ХХҮГ-тай хамтран зохион байгууллаа.	100
2.2.Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах			
4	2.2.1.Төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэн,өр авлагагүй ажиллана	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2017 оны сургалтын хөтөлбөрийн дагуу Сангийн яамны сургалтанд санхүү албаны дарга,байгууллагуудын нягтлан бодогч нар хамрагдлаа. Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээний Freebalance программ ашиглан төрийн сан үйл ажиллагаагаа явууллаа.Энэ жил харъяа төсөвт 15 байгууллагын 54 дансаар нийт 5329 ш төлбөрийн хүсэлтээр 8,182,998,054 төгрөгний гүйлгээ шивж гүйцэтгэснийг хянан баталгаажуулж дамжууллаа. Сумын 2017 оны тодотгосон төсөв 9,513,233.7 мянган төгрөг. Тодотголоор зайлшгүй үүсэх өрийн судалгаа гарган төсөвт зохицуулалт хийж оны эцсээр өр үүсэхгүй, авлагыг буурууллаа.	100
5	2.2.2Төсвийн зарцуулалтанд тавих хяналт, үнэлгээг иргэд ТББайгууллагаар гүйцэтгүүлнэ	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан аудитлагдаж зөрчилгүй санал дүгнэлт авлаа. Тус тайланг харъяа төсөвт 15 байгууллага, 7 сангийн санхүүгийн тайланг нэгтгэлээ. ОНХСангийн 2016 оны үйл ажиллагаанд нийцлийн аудит хийгдэж, зөрчилгүй дүгнэлт авлаа.	100
6	2.2.3Байгууллага бүрийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж,төсвийн шууд захирагч,нягтлан бодогчдын ажлын хариуцлагыг сайжруулна.	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсвийн мэдээллээ хуулийн хугацаанд байршуулж илгээлээ. 1-3-р улирлын сумын нэгтгэсэн тайлангаар 92 хувьтай. Байгууллага бүрийн мэдээллийн санг хянан , заавар зөвлөмжийг тухай бүр өгч ажиллалаа. Үр дүнгийн гэрээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг үзүүлэлтээр тусган хэрэгжилтийг дүгнэлээ..	100

7	2.2.4.Татварын орлогын төлөвлөгөөг жигд биелүүлэхэд төрийн албан хаагчдын ажлын уялдаа,хариуцлагыг нэмэгдүүлнэ	Багийн засаг дарга нартай галт зэвсэг, бусад татвар төлөлтийн талаар мэдээлэл солилцож, татварын дутууг төлүүллээ. 11 сарын ОНО –ын биелэлт 216,807,7 гүйцэтгэл 216,403,2 мян 99,9 хувь биелээд байна. Багийн засаг дарга , мэргэжилтэнүүдийн хамтран ажилласан орлого 20,924,0 мян төгрөг байна. Сумын авто тээврийн татвар төлөлт 88 %-тай ,татварын орлогыг биелүүлэхэд анхаарч, урьд оны өртэй татвар төлөгчдийн өр барагдуулах ажлыг төлөвлөж гүйцэтгэснээр үйл ажиллагааны орлого биеллээ. /60,203,3 мянган төгрөг/.Аймгийн цагдаагийн хэлтэстэй хамтран “Галт зэвсэг -2017” аян зохион байгуулж, 2399,0 мянган төгрөгийн татвар төвлөрүүлээ.	70
ГУРАВ.НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД <i>Зорилго:Иргэдийн эрүүл аюулгүй орчинд сурч, хөгжих, ажиллаж ,амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамрагдах боломжийг бий болгох замаар хүний хөгжлийг дээдэлнэ</i>			
3.1. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах			
1	3.1.1Иргэдийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулж, В,С вирусийн илрүүлэлт,эмчилгээг сайжруулж, зонхилон тохиолдох хавдрын өвчлөлийг бууруулна.	Сумын ЭМТөв ЭДЦСургууль , Такси үйлчилгээ , Ган-Илч ХХК-ийн нийт 166 ажилчдад илрүүлэг үзлэгийг зохион байгууллаа. В вирустэй-14 , С вирустай -12 иргэдийг дараагийн шатлалд шилжүүллээ. Сумын харьяа байгууллагын албан хаагчид эрт илрүүлэг үзлэгт бүрэн хамрагдаж, С вирустэй 5 ,В вирустэй 7 албан хаагчийг дараагийн шатны арга хэмжээнд хамрууллаа. Нийт зорилтот насны 1103 иргэн шинжилгээнд хамрагдахаас 363 буюу 32,9%-ийг шинжилгээнд хамруулж, 1,089,000 төгрөгийг эрүүл мэндийг дэмжих сангийн зардлаас шилжүүллээ. Элэг бүтэн Монгол хөтөлбөр хэрэгжиж нийт 1020 иргэдээс 92,4%-нь хамрагдаж, С вирустай-128, В вирустай-87 иргэн, 20 дээш насны нийт 570 иргэн шинжилгээнд хамрагдснаас 55 иргэнд С вирус , 57 иргэнд В вирусын халдварыг илрүүлэн дараагийн шатлалд шилжүүллээ. Хөх ба Рар шинжилгээнд хамрагдах эмэгтэйчүүдийн судалгааг гаргалаа. Хөхний үзлэгт хамрагдах 845 эмэгтэйгээс 807 буюу 93,2 %,умайн хүзүүний хавдар илрүүлэх РАР шинжилгээнд зорилтот бүлгийн 323 эмэгтэй хамрагдахаас 267 буюу 82,6 % хамрагдлаа. АГ үзлэгт 1073 иргэн хамрагдахаас 100 % , ЧЖ үзлэгт -1119 иргэн хамрагдахаас 100 % хамрагдлаа. Нийт үзлэгийн дундаж хувь 93,95 %-тай байна. Энэ нь 2016 оны эхний 10 сарын үзүүлэлт 86,1% байсан бөгөөд 7,85%-иар өссөн байна.	100
2	3.1.2Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”ийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, хүүхдийн өвчлөлийг бууруулна.	Эрүүл мэндийн төв нь шинэчилсэн маягтын дагуу 130 жирэмсэн эх шинээр авч эрт хяналт 118 буюу 90,7 % тай байна.2016 онд 89,8% байсан бөгөөд 2017 онд эрт хяналтын хувь 1%-иар өссөн байна. 1,3,7 цэцэрлэгүүдэд шүдний нарийн мэргэжлийн эмч ажилллаж, хүүхдүүдийн шүдийг эрүүлжүүлэн эм түрхлээ. ДЗОУБ-тай хамтран 5 цэцэрлэгийн хүүхдүүдэд шүд угаах дадлыг хэвшүүлэх сургалтыг зохион байгуулж сургалтын төгсгөлд бүх хүүхдүүдэд шүдний сойз , сүү бэлэглэн нийт 838,000 төгрөг зарцууллаа. Нийт 12655 үзлэг хийснээс 1806 буюу 14,27 % гэрийн идэвхтэй эргэлтээр эргэсэн байна. Энэ нь өмнөх оны тоон үзүүлэлтээс 3%-иар буюу 367 үзлэгээр өссөн байна. Гэрийн идэвхтэй эргэлтээр санал гомдолгүй ажиллалаа.	100

3	3.1.5 Сумын ЭМТөвийн зүрхний цахилгаан бичлэг, зөөврийн ЭХО аппаратыг тогтмол ажиллуулна.	Зүрхний цахилгаан бичлэгийг 35 иргэнд хийлээ. Аппаратын тохируулга хийлгэхээр албан тоотой Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлээ. Эмч нарыг зүрхний цахилгаан бичлэг хийхэд мэргэшүүлэх шаардлагатай байна. ЭХО-д 171 иргэдийг харж үйлчиллээ. Үүнд жирэмсэн эх -112 дотрын өвчлөл 59 байлаа.Жирэмсэн эхийг ЭХО-д харснаар тээлтийн хугацааг зөв тодорхойлж , ургийн хөдөлгөөн болон зүрхний цохилтын тоо зэрэг үзүүлэлтүүд хэмжигдэхэд ач холбогдолтой байлаа.	100
4	3.1.9Төрийн болон ТББайгууллага, хувийн хэвшил,иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэн ”Эрүүл хот,сум,баг,байгууллага,өрх,иргэд” -ийг шалгаруулна	“Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”аар 4 цэцэрлэг , 3 цэцэрлэг тус тус шалгарч өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагналаа. Эрүүл мэндийг дэмжих зардлаас 180,000 төгрөг зарцууллаа. Эрүүл мэндийг дэмжигч өрх”өөр Д.Эрдэнэ-Оюун /Наран баг /, Н.Цэрэндавга /Тэвш баг /, Д.Бат-Эрдэнэ / Далай баг /, Д.Ганпүрэв /Үйзэн баг /, тус тус шалгарч өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагналаа. Эрүүл мэндийг дэмжих зардлаас 150,000 төгрөг зарцууллаа. “Эрүүл иргэн” Ч.Тунгалаг / Наран баг / , 3.Энхтуяа /Тэвш баг/, Х.Мөнхцэцэг / Далай баг / ,М.Мөнхбат /Үйзэн баг /тус тус шалгарч өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж, эрүүл мэндийг дэмжих зардлаас 142,000 төгрөг зарцууллаа.	100
5	3.1.10Хөдөөгийн малчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна	Малчдад зориулсан эрүүл мэндийн боловсрол сургалтаар жирэмсэн 65 эхчүүд болон гэр бүлд зориулсан сургалт , малчдын золголт-157, урьдчилан сэргийлэх үзлэгээр сургалт-2978, осол гэмтлээс сэргийлэх сургалт -74, БЗДХӨ-ний сургалт-300 нийт 12 удаагийн сургалтаар 3574/давхардсан тоогоор/ иргэдийг сургалтанд хамрууллаа. Хөдөөгийн 5215 иргэдэд үзлэг хийснээс 2789 буюу 53,48% нь урьдчилан сэргийлэх үзлэг байлаа.0-5 насны хүүхдүүдийг өсөлт жинлэлтэнд хамруулж А болон Д аминдэмийг нийт 2682хүүхдэд уулгалаа .	70
6	3.1.11Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт,сурталчилгааг тогтмолжуулж, эрүүл зан үйл,хандлага дадлыг төлөвшүүлэх, тэдний санал санаачлагыг дэмжинэ.	ЗЦТ, Авто тээврийн газар, ЭМГ-тай хамтран такси үйлчилгээ эрхэлж буй нийт 72 таксины жолоочид “Бага насны хүүхдийг осол гэмтэл”-ээс сэргийлэх мэдээлэл, сургалт хийж, ХБӨ-ний илрүүлэгт хамрууллаа. Илрүүлэг үзлэгээр нийт оролцогчдын 65,3 хувь нь жингийн илүүдэлтэй, 0,8 хувь нь В вирустай, 12,2 хувь нь С вирустай, 36,7 хувь нь артерын даралт өөрчлөлттэй байсан бөгөөд зөвлөгөө өгч дараагийн шатлалд шилжүүллээ Танхимын сургалтаар нийт 4414 иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамрууллаа. МСС-ны 70 төрлийн 6500 орчим материал тараалаа. Үүнд:БЗДХӨ/ХДХВ/ДОХ-ын сургалт 5 сургууль, МСҮТ-1373 ,5 цэцэрлэгийн 600 хүүхдэд амны хөндий ЭА сургалт 5 сургууль, МСҮТ-ын 15 дээш насны охидод-199,7 багийн өдөрлөг-Элэг бүтэн Монгол сурталчилгаа ,3 багийн өдөрлөг-Осол гэмтэлгүй баг МСС материал, үзлэг ,Ахмадын сургалт Ган-Илч ХХК ХБӨ сэргийлэх сургалт , Жирэмсний сургалтыг 3 удаа зохион байгуулж 128 жирэмсэн хамруулж жирэмсний аюултай шинж, гарын авлага-100 ширхэгийг тараалаа. Нийгмийн халамж үйлчилгээний дэргэдэх ахмадын сувилалд хэвтэн эмчлүүлж байгаа 17 ахмадуудад “Тархинд цус харвалт”-аас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, тэдний артерийн даралтыг үзэж шаардлагатай ахмадад хөнгөлөлттэй эмийн жор бичиж үйлчиллээ.Харвалтын эрсдлийн үнэлгээг 5 багийн нийт 160 ахмад настанд хийлээ. Үр дүнгээс: 17,4 % нь өндөр эрсдэлтэй,32,7 % нь дунд эрсдэлтэй 48,8 % нь бага эрсдэлтэй байлаа. Өндөр эрсдэлтэй ахмад настуудыг багийн эмчийн хяналтанд авч зөвлөгөө мэдээллээр хангалаа.	100

7	3.1.12 Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувийг сумын хэмжээнд нэмэгдүүлэхэд хамтарсан багийн үйл ажиллагааг дээшлүүлэх	Багийн засаг дарга нартай хамтран үзлэгт хамрагдах иргэдийн нэрсийг гаргаж ажиллалаа. Хамтарсан багийн сургалтанд гишүүдийн хамт оролцлоо. Багуудаас Наран баг бүх үзүүлэлт хангалттай, жирэмсний хожуу хяналт байхгүй, умайн хүзүүний хавдар илрүүлэх РАР шинжилгээнд 100 % хамрагдсан байна. “Элэг бүтэн монгол” хөтөлбөрөөр Наран баг 92,6, Тэвш баг 87,9% , Далай баг 86,6 % Үйзэн баг 90,2 % , Нарлаг баг 95,6%, “Артерийн гипертензи “ Наран баг 91,4 % , Тэвш баг 90,5 % , Далай баг 81,0 % , Үйзэн баг 91,5 % ,Нарлаг баг 91,4 % ,Чихрийн шижин Наран баг 92,6 % , Тэвш баг 87,9 % , Далай баг 86,6 % ,Үйзэн баг 90,2 % , Нарлаг баг 95,6 % нь хамрагдалттай байна.	70
8	3.1.13 Иргэдийн дунд БЗДХӨ-ний өвчлөлийг бууруулах ажлыг зохион байгуулна	Тэмбүүгийн шинжилгээг 120 иргэнд авч сургалтыг өөрчлөлттэй гарсан 21 иргэдийн шинжилгээг НЭ-т баталгаажуулан 3 иргэнд халдвартын эмчтэй хамтран эмчилгээг хийлээ. “Эрүүл цус” аяны хүрээнд 440 иргэдээс ХДХВ болон Тэмбүүгийн шинжилгээ авч өөрчлөлттэй гарсан 15 шинжилгээний цусны дээжийг Нэгдсэн эмнэлгийн лаборторит хүргүүлээ .Цэрэг татлагаар 118 залуучууд ,жирэмсний хяналтанд орсон 130 эхээс шинжилгээг авсан шинээр БЗДХӨ-ийн бүртгэгдээгүй .Нийт 808 иргэдээс шинжилгээ авснаас 368 иргэдийн шинжилгээг эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийг дэмжих зардлаас 920,000 , Глобаль сангийн төслийн санхүүжилтээс 1,925,000, Нийт 2,845,000 төгрөг зарцууллаа. Дэлхийн ДОХ-той тэмцэх өдрийг тохиолдуулан төвийн ШТСтанц 11 , ЗДТГазар, Хот тохижуулах газар, Нандин ресторан зэрэг ААНэгж байгууллагын 400 албан хаагч, ажилчдад ДОХ-ын өдөрт зориулсан улаан тууз зүүж, гарын үсгийг нэгтгэлээ.Энэ өдөр 150 ширхэг гарын авлага, 400 ширхэг бэлгэвч, 150 ширхэг улаан туузыг бэлтгэн, сайн дурын шинжилгээнд 20 иргэнийг хамрууллаа. Хот тохижуулах газрын хамт олонд халуун аарц жигнэмэгээр дэмжлэг үзүүлээ. Нийт 150000 төгрөг зарцууллаа.	100
9	3.1.14. Сумын цэцэрлэгүүдийг эмчтэй болгох асуудлыг шийдвэрлэнэ.	Сумын 7 цэцэрлэгийн 1 цэцэрлэг бие даасан эмчтэй болж, 6 цэцэрлэг гэрээт эмч ажиллуулан хүүхдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүргэлээ. ЭМГазраас 245 хүүхдийг цагаан хорхойн шинжилгээнд хамрууллаа. Эмч нар хүүхдүүдийг витаминжуулан , вакцинжуулалтын судалгаа гарган үр дүнг тооцлоо. Дэлхийн гар угаах өдрөөр эцэг эхчүүдэд Гар угаахын ач холбогдол сургалтыг зохион байгууллаа.	100
3.2. Боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх			
10	3.2.1. Хүүхдийг иргэн болгон төлөвшүүлэхэд эцэг, эхийн хяналт,оролцоог нэмэгдүүлнэ	Эцэг эхчүүдтэй хамтран бага насны хүүхдийн хөгжлийн арга хэмжээнд хүүхдийг хамруулахад багш нар хангалттай ажиллалаа.Аймгийн Засаг даргын нэрэмжит “Оюун ухааны олимпиад”-дад 7 цэцэрлэгийн 4-5 настай 79 хүүхэд оролцлоо. 5 настны төрөлд 1-р байранд 3-р цэцэрлэг, 2-р байранд 6-р цэцэрлэг, 5-р цэцэрлэг, 3-р байранд 6-р цэцэрлэг, 4-р цэцэрлэг шагналт байрын эзэд боллоо.4 настны төрөлд 1-р байранд 5-р цэцэрлэг, 2-р байранд 4-р цэцэрлэг, 1-р цэцэрлэг, 3-р байранд 3-р цэцэрлэг, 6-р цэцэрлэг тэргүүлээ.Тоуа хүүхэд хөгжлийн академитай хамтран баруун тархи хөгжүүлэх Соробан сампингийн сургалтыг зохион байгуулж, сургалтанд 18 хүүхэд хамрагдсанаас улсын хэмжээнд зохион байгуулагдсан тэмцээнд 3 хүүхэд оролцож шилдэг 8 хүүхдээр тодорлоо.IQ-ийн олимпиадийг 2-5-р ангийн сурагчдыг насны ангиллаар сургууль бүрт зохион байгуулж тэргүүлсэн сурагчдыг аймгийн олимпиадад амжилттай оролцууллаа. ОЮУН УХААНЫ ОЛИМПИАД”-ыг тохиолдуулан цэцэрлэгүүд 1-р шатыг цэцэрлэгтээ зохион байгуулж, 4-5 насны төрөлд нийт 577 хүүхэд амжилттай оролцлоо.	100

11	3.2.2СӨБ-ын багш нарт зориулсан "Багш бүрт компьютер" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	БСШУСЯ-наас 1-р цэцэрлэг, 4-р цэцэрлэг, 6-р цэцэрлэгт 4 ширхэг компьютер, өнгөт принтер 2-ыг олголоо. Мөн 1,2,3,4,5,6,7, цэцэрлэгүүд дотоодын нөөц бололцоог ашиглан хандивын шугамаар багш нарын компьютерын хэрэгцээг хангалаа	100
12	3.2.4Мандал сургуулийг "Цахим сургууль" хөтөлбөрт хамруулж, стандартад нийцсэн орчин үеийн техник хэрэгслээр бүрэн хангана.	Хийгдээгүй үнэлэх боломжгүй	-
13	3.2.5Ахмад настан, залуучууд, хүүхэд багачуудын гурван үеийн алтан хэлхээг бэхжүүлэх ажлыг монгол ёс уламжлалд тулгуурлан хэрэгжүүлнэ	Ахмад багш нарын аймгийн зөвлөгөөнд тус сумын харьяат 100 гаруй ахмад багш оролцлоо. Зөвлөгөөнд багш нарын ажлын туршлага, арга барил цаашид сурталчилан таниулах талаар хэлэлцлээ. Зөвлөгөөнөөс 11 хүний бүрэлдэхүүнтэй ахмад багш нарын холбоог байгууллаа. Засаг даргын А/94 тоот захирамжаар Засаг даргын дэргэдэх ахмадын зөвлөх зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, 1 удаа хуралдаж цаашид хэрэгжүүлэх ажлын талаар санал бодлоо солилцож, зөвлөх зөвлөлийн тэргүүнээр Д.Аюур ажиллаж байна.	70
14	3.2.6"Хүүхдэд ээлтэй дотуур байр" хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2016-2017 оны хичээлийн жилд 2 сургуулийн 3 дотуур байранд 13 сумын 186 хүүхэд амьдарлаа. "Хүүхдэд ээлтэй дотуур байр" аяны хүрээнд Дэлхийн зөн ОНХХ-өөс 888.200 төгрөгний төсөвтэй сургалт, хүмүүжлийн дуут жагсаал, хэн сайн дуулах вэ?, ЭМТ-ийн мэргэжилтэн, сургуулийн эмчтэй хамтран өсвөр насны охид хөвгүүдэд БЗХӨ-ний сургалтууд, дотуур байрны хөвгүүдэд шагайн харвааны дугуйлан, тэмцээн уралдааныг явууллаа. Сурагчдын төлөвшил хүмүүжил, орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 14.4 сая төгрөгийн 9 төсөл хэрэгжүүллээ. ЭДЦСургууль,ГИЦСургууль сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар "Хүүхдэд ээлтэй дотуур байр" хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцүүлээ. Дотуур байрны 3 багш, 4 байрын жижүүр нар аймгийн боловсрол соёл урлагийн газарт зохион байгуулагдсан 2 өдрийн сургалтанд хамрагдлаа. ГИЦСургууль хүүхдийн хоолны амт чанар, үе тэнгийн дарамт шахалт, дотуур байрны орчны талаар хүүхдүүдээс судалгаа авч хоолны орц, нэр төрлийг өөрчилж, тасгуудын гэрэлтүүлгийг шинэчилж, хоолны заалыг тохижуулах, сурагчдын ус уух хэвшлийг тогмолжуулж 400000 төгрөгний үнэ бүхий ус цэвэршүүлэгчийг байршуулж,орчин нөхцлийг сайжрууллаа.	100
15	3.2.7.Багшийн хөгжил, ажлын үнэлэмжийг дээшлүүлж, гадаад дотоодод сургалтанд хамруулах замаар чадварлаг багшийн тоог нэмэгдүүлнэ	Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ерөнхий боловсролын сургуулиудтай 7 хоногийн хугацаатай "Багш-Сурагч " солилцоо хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж, 2 аймгийн 14 сурагч, 12 багш харилцан туршлага судаллаа. Сургууль, цэцэрлэгийн багш нар хичээлийн жилд Зөвлөх багш-2, мэргэжлийн тэргүүлэх зэрэгтэй-2, магистрын зэрэгтэй-3 багштай болж, багш нарын ур чадвар жилээс жилд нэмэгдэж байна. ЕБСургуулиудад Дорноговь аймгийн лаборатори 2-р сургууль, Төмөр замын 2-р сургууль, Говьсүмбэр аймгийн "Сайн хичээл –сайн туршлага" зөвлөгөөнд, Нийслэлийн 84,20, 92 –р сургуулиудад нийт тоогоор 103 багш туршлага судаллаа. Хүмүүнлэг сургуулийн багш сурагчид Завхан аймгийн Идэр суманд болсон "Эх хэлний их сорилго" уралдаанд 2 багш,13 суралцагчийн хамтаар оролцож, багаараа тэргүүн байр эзэллээ.Мөн тус сургуулийн нийт 10 багш Луус сумын дунд сургуулийн "Багш хөгжлийн үйл ажиллагаатай танилцаж харилцан туршлага судаллаа. Цэцэрлэгүүд аймаг сумын засаг дарга,БСУГ, Дэлхийн зөн ОНХХ-ын дэмжлэгтэйгээр Эрээн хот, ОХУ, Улаанбаатар хот, бусад аймгийн нийт 44 цэцэрлэгийн үйл ажиллагаатай 150 гаруй багш давхардсан тоогоор	100

		харилцан туршлага судалж, сургалтанд хамрагдлаа.	
16	3.2.8. МУ-ын гавъяат багш Н.Өлзийн нэрэмжит улсын математикийн нээлттэй олимпиадыг жил бүр уламжлал болгон зохион байгуулна	МУГБ Н.Өлзийн нэрэмжит математикийн улсын нээлттэй 17 дахь олимпиад тус сургууль дээр боллоо.Тус олимпиадад Улаанбаатар хотын 1,11,84, Сант, Соёмбо, Орчлон, Эрхэт-Эрдэм, Номун, Оргил, Шинэ-Үе, Архангай аймгийн 1 дүгээр сургууль, Өвөрхангай аймгийн Мэргэд, 1-р сургууль, Өмнөговь аймгийн 1,2,3,4 дүгээр сургууль, Баянхонгор аймгийн сургууль, сургалтын төв, өөрийн сумын 5 сургуулиудаас нийт 745 суралцагч, 36 бага, дундын багш оролцлоо. Олимпиад 2-12 дугаар анги, бага, дундын багш гэсэн 13 ангиллаар явагдаж ангилал тус бүрт эхний 3 байрыг шалгаруулж, медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа.	100
3.3.Биеийн тамир,спортын арга хэмжээнд иргэдийг хамруулах			
17	3.3.2Спортын “Бага олимп”зохион байгуулна	Дундговь аймгийн "Нэг зорилго-нэг баг" уриатай “Бага олимп”-2017 спортын тэмцээнд сумын төв хөдөөгийн багууд 3 багт хуваагдаж амжилттай оролцлоо. Тэмцээнд нийт 201 тамирчид спортын 7 төрлийн 216 багц медалийн төлөө өрсөлдөж нийт 22 медаль хүртлээ. Үүнээс: Алт-10 Мөнгө-9 хүрэл-4 Багийн нийт дүнгээр Наран, Далай, Нарлаг багийн баг тамирчид тэргүүлж, Үйзэн, Арвижих, Айраг багийн баг тамирчид гутгаар байранд шалгаран Цом, өргөмжлөл хүртлээ.	100
18	3.3.3. Суманд шинээр байгуулагдах спортын холбоо, хамтлагийн үйл ажиллагааг дэмжинэ	Сумын хэмжээнд үндэсний сураар хичээллэдэг иргэд, хүүхдийн судалгааг гаргалаа. Үндэсний сур харвадаг , хичээллэдэг нийт 31 иргэнтэй. Үүнээс: аймгийн мэргэн-7 , спортын мастер-4, дэд мастер-1 ,1-р зэрэгтэй аймгийн мэргэн харваач-3 , 11 хүүхдээс , идэвхитэй харваач 9 , зэргийн шаардлага хангасан 3 хүүхэд байна. МГСС-ийн сурагч О.Мөнхсайхан 2017 онд I-зэрэг хүртлээ.	100
19	3.3.4Биеийн тамираар хичээллэх, хөдөлгөөний хомсдлоос урьчилан сэргийлэх арга хэмжээг багийн иргэдийн дунд жил бүр зохион байгуулна	Сургуулиудын биеийн тамирын багш нар волейбол, сагсан бөмбөгийн дугуйлан хичээллүүлж сурагчдыг бэлтгэж байна. Улсын чанартай тэмцээн уралдаанаас Волейбол- 26, Сагсан бөмбөг- 1, Жудо-1, Хөнгөн- 5, Таскандо-21 сурагчид амжилт үзүүлээ. Сурагчдын лиг”-2017 “Волейбол”-ын тэмцээнийг зохион явууллаа. Тэмцээнд 5 сургуулийн эрэгтэй, эмэгтэй 10 багийн 120 гаруй тамирчид оролцлоо. Эрэгтэй ЭДЦСургууль, ГИЦСургууль , МГССургууль, эмэгтэй ЭДЦСургууль,МГССургууль, ГИЦС-ийн баг тамирчид тус тус эзэллээ. Сумын төсвийн байгууллагуудын ажилчин албан хаагчдын дунд волейбол-102, сагсан бөмбөг-126 , теннисны тэмцээн-130, даам-26 нийт 4 төрлийн тэмцээнийг зохион явуулж, давхардсан тоогоор нийт-384 ажилчин албан хаагч оролцлоо. Тэмцээнийг төсөвт байгууллагууд хариуцан зохион байгууллаа. Хөдөлгөөн эрүүл мэнд өглөөний дасгал хөдөлгөөнд төсөвт байгууллагууд идэвхитэй оролцлоо. ЭМГ-тай хамтран “Өглөөний дасгал гүйлт” ,“Уран хөдөлгөөнт гимнастик арга хэмжээг зохион байгуулж,шагналын санд 100,000₮ зарцууллаа./ Төвийн багуудын дунд хөл бөмбөг, волейболийн тэмцээн, хөдөөгийн багийн залуучуудын дунд волейболын тэмцээнийг зохион байгуулж, 130 гаруй тамирчид оролцлоо.	100
3.4.Соёл урлагийг хөгжүүлэх			
20	3.4.1“Дундговь- Дуу хуурын өлгий” соёл урлагийн өдөр, байгууллагуудын дунд урлагийн үзлэг зохион байгуулна.	Багш нарын “Урлагийн бага наадамд 6 төрлөөр сургууль цэцэрлэгүүдээс нийт 246 багш , ажилчид оролцож, Тэргүүн байрыг Мандал сургууль, дэд байранд МГССургууль, тусгай байранд ГИЦСургууль шалгарлаа.Багш нарын авьяасыг тодруулах арга хэмжээ боллоо.	100

21	3.4.3Хүүхэд бүрийн авьяасыг нээн хөгжүүлэх, дуу хөгжим, зураг, технологийн хичээлийн тайланг эцэг эхэд сурталчилна	Ардын боловсролын тэргүүний ажилтан, ахмад багш М.Алтангэрэлийн нэрэмжит “Залуу зохион бүтээгч” уралдааныг зохион байгууллаа. Энэ жил аймгийн засаг дарга 800000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Уг тэмцээнд 2 насны ангилалд 50 хүүхэд оролцлоо. Сургуулиуд технологи, зураг зүй, физикийн хичээлээр сурагчдыг авьяас чадварыг хөгжүүлж 598 сурагчийг хамруулан, эцэг эхчүүдэд тайлант өдөрлөгийг зохион явууллаа Сумын 7 цэцэрлэгийн дуу хөгжмийн багш нар бүлэг бүрт дуу хөгжмийн хичээлийн дагуу тайлант өдөрлөгүүдийг 3-4 удаа зохион байгуулж эцэг эхчүүдэд танилцуулан, хүүхдийн хөгжилд үнэлгээ дүгнэлт хийлээ. Сумын хэмжээнд 2 бүлэг ТХДЖТ, ТТХТ-т тайлан тоглолт хийлээ. 6-р цэцэрлэг 5 бүлгийн 160 хүүхдийг хамруулан ТТХТ-т тайлант өдөрлөгийг зохион байгууллаа.	100
22	3.4.4Өрх бүр угийн бичгээ хөтөлцгөөе”аяныг өрнүүлэн, нийт өрхийн 70-аас доошгүй хувийг угийн бичигтэн болгож,гэрчилгээ олгоно.	Угийн бичиг хөтлөх аяныг эрчимжүүлэх зорилгоор Угийн бичигтэн иргэн болон багийг шалгаруулах болзол аяныг зохион байгуулж байна. Аяныг сумын засаг даргын дэргэдэх ахмадын зөвлөлийн дарга Д.Аюуртай хамтран Сүүнцагаан Сайнцагаан сонинд угийг бичгийг хэрхэн хөтлөх талаар мэдээллийг оруулж, сургалтыг байгууллага иргэдийн дунд зохион байгууллаа. Одоогийн байдлаар угийн бичиг хөтөлсөн иргэдийн нэгдсэн судалгааг давхардсан тоогоор гаргаж, 280 төрийн албан хаагч, 19778 өрх, 80694 иргэн, бүрэн хөтөлсөн 61, хөтөлж байгаа-213 иргэн байна. 2016 оны жилийн эцсийн тоо баримтаас Угийн бичиг хөтөлж эхэлсэн өрх иргэдийн тоо энэ оны эцсээр 8%-иар өссөн байна. Угийн бичиг үлгэр жишээ хөтөлсөн 3 өрх,иргэнийг шалгаруулж шагнахаар боллоо.	100
23	3.4.6.Сургуулиудын номын санд “Цахим номын сан”бий болгоно	Цахим сургууль хөтөлбөр ЭДЦС, ГИЦС, 3-р сургууль дээр хэрэгжүүлэхээр БСШУСЯ-аас шийдвэрлэлээ. Дэлхийн зөн ОНХХ-ийн санхүүжилтээр ГИЦСургуульд 1950000 төгрөгний 10 ширхэг номын тавиур хүлээн авч номын хадгалалт хамгаалалт сайжирч, МГССургуульд номын фонд нэмэгдүүлэх, суудлын тоог нэмэглүүлэх 1467000 төгрөг, Хүмүүнлэг сургуульд 1245000 төгрөгийн Монгол хэлний тайлбар толь 50 ширхэг номоор тус бүр дэмжлэг үзүүллээ. Сургуулиуд хүүхдийг ангидаа ном унших орчинг бүрдүүлж, цагийн хуваарь гарган ажиллалаа. Шинэ ном болон тэмдэглэлт баярыг тохиолдуулан номын үзэсгэлэн гаргалаа.	100
3.5.Гэр бүл,хүүхэд,залуучуудын оролцоо,хөгжил,сайжруулах			
24	3.5.1”Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих”аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Сумын хэмжээнд хамгаалал шаардлагатай 85 гэр бүлийн судалгааг гаргалаа. Сумын хүүхэд хамгааллын баг, ГБХЗХГазар, ЦГ-тай хамтран “Жаргалтай гэр бүл” аяныг зохион байгууллаа. Тус аянд зорилтот бүлгийн 40 өрхийг сонгож, нөхцөл байдлын үнэлгээ хийж, гэрийн даалгавар өгч ажиллалаа. 40 өрхийн архины хамааралтай гишүүдийг “АА” сургалтанд хамрууллаа. Гэр бүл бүрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж 8 модуль сургалт анхаарал шаардлагатай гэр бүлүүдэд нөхцөл байдлын үнэлгээ хийж, сургуулийн насны 77, цэцэрлэгийн насны 36 хүүхэд, байгаагаас 10 хүүхдэд зөвлөгөө өгч нөхөн сэргээх үйлчилгээ үзүүллээ. Боржигон багийн 2 гэр бүл,4 хүүхдэд хувийн хэрэг нээн хамтарсан багийг цаг тухайд хуралдуулан асуудлыг шийдвэрлэлээ. Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран үзлэг шинжилгээнд хамрууллаа.Байгууллагуудын хүүхэд хамгааллын бодлого боловсруулж, нийт эрсдэлт бүлгийн өрхөд зочилж, АУБагш, нийгмийн ажилтантай хамтран зорилтот бүлгийн сурагчид, эцэг эхчүүдтэй хамтран ажиллалаа.Хүүхдийн эрхийн зөрчилтэй асуудлыг тухай бүр холбогдох иргэдэдтэй уулзан шийдвэрлэлээ.	100

25	3.5.2.Залуучуудын хөгжлийг дэмжсэн уулзалт,сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулна.	Сумын залуучуудын чуулга уулзалтанд харьяа төсөвт байгууллага, 9 багийн багш, ажилчид албан хаагч, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарын нийт 129 төлөөлөгчид хамрагдлаа. Чуулга уулзалтын үеэр Хөгжлийн гарц –Миний оролцоо сэдэвт илтгэлийн уралдаан зохион байгуулж, эхний 3 байрыг шалгарууллаа. Залуучуудын чуулга уулзалтаас ГИЦСургуулийн багш Б.Ууганцэцэгийн “Оролцоотой оюунлаг иргэн орон нутгийн хөгжлийн гарц болох нь” илтгэлийн төслийг Засаг даргын 2018 оны үндсэн чиглэлд оруулахаар боллоо. Залуучууд орон нутгийн хөгжилтэй холбоотой 4 чиглэлээр 29 санал гаргалаа.	100
26	3.5.3 Сумын залуучуудын холбооны үйл ажиллагааг сайжруулна	Сум залуучуудын холбоог шинэчлэн байгуулж,Нарлаг багийн иргэн Б.Мөнх-Орших тэргүүнтэй,тэргүүлэгч 9 гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдлаа. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг сурталчилсан арга хэмжээнд төсөвт байгууллагуудын нийт 2000 залуучууд хамрагдаж , байгууллага тус бүрт залуучуудын бүлгэмийн үйл ажиллагааг тусгай хөтөлбөрөөр явууллаа.	100
27	3.5.4Салбарын тэргүүний шилдэг залуучуудыг шалгаруулна	Сумын засаг даргын захирамжаар Шилдэг залуучуудыг шалгаруулах журмыг баталлаа.Журам нь залуучуудын мэдлэг чадварыг үнэлэх,түгээн дэлгэрүүлэх,тэдний санал санаачлагыг орон нутгийн хөгжилд чиглүүлэх зорилготой болно.Шилдгүүдийг тодорхойлолтын дагуу оны эцэст шалгаруулна.	70
28	3.5.5Сумын хүүхэд хамгааллын бодлогыг боловсруулна.	Сумын ИТТХ-ын 49-р тогтоолоор сумын хамтарсан багийг байгуулан хүүхэд хамгааллын бодлогыг боловсруулж батлууллаа. Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд Халамж анхаарал шаардлагатай 229 хүүхдийн судалгааг гаргалаа. Анхаарал шаардлагатай сургуулийн насны 77 хүүхэд, цэцэрлэгийн насны 36 хүүхэд, 2 гэр бүлд хувийн хэрэг нээн 10 хүүхдэд зөвлөгөө өглөө. Сумын хэмжээнд үрчлэгдэн , хараа хяналт , халамж анхаарал шаардлагатай , бүтэн өнчин хүүхдийн мэдээллийн санг бүрдүүллээ. Насан туршийн боловсрол төвд суралцаж байгаа эцэг эхийн хараа хяналт султай 5 хүүхдийг насан туршийн боловсрол төвийн арга зүйч багийн засаг дарга, нийгмийн ажилтнууд хамтран сургалтанд хамрууллаа. Сумын хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар 8 хүүхэд үрчлэгдэн , бүтэн өнчин 16 , хараа хяналт , халамж анхаарал шаардлагатай 229 хүүхдийн судалгааг гаргалаа.	100
29	3.5.6Тэргүүний гэр бүл, хүүхдийг алдаршуулах арга хэмжээг зохион байгуулна	“Тэнгэрлэг гэр бүл”ийг 5 номинацаар шалгаруулж , Авьяаслаг гэр бүлээр Нарлаг багийн иргэн М.Наранбаатар, Спортлог гэр бүлээр Нарлаг багийн иргэн Д.Болор-эрдэнэ, Оюунлаг гэр бүл, Айраг багийн иргэн Б.Хүрэлчөдөр , Бүтээлч гэр бүлээр Айраг багийн иргэн Б.Ганхуяг, Өнөр гэр бүлээр Арвижих багийн иргэн Д.Бат-очир нарыг шалгарууллаа.Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Шилдэг хүүхдийн жагсаалыг зохион байгуулж, 200 гаруй шилдэг хүүхэд, оролцооны байгууллагын 100 гаруй хүүхэд тус тус оролцлоо. 2016-2017 оны хичээлийн жилд сурлага урлаг спортын амжилт гаргасан 40 гаруй төгсөгч аймгийн засаг даргын жуух , ГБХЗХГ-ын авьяас алт, мөнгө, ТТХТ-ийн медалиудаар тус тус шагнуулж , сумын ЗДТГазар Шилдэг 5 төгсөгчийг “Шилдэг хүүхэд” цом , дурсгалын зүйлээр шагналаа.	100
30	3.5.7“Номын амт “ хүүхдийн утга зохиолын бага наадмыг зохион байгуулна	“Бага тайз-2017” урлагийн их наадамд ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдийг 5 төрөлд оролцууллаа. Аймгийн Уран жиргээ, Дэгдээхий нас,,Бага тайз, “Үлгэр амьлах цагаар 2017” жүжгийн уралдаан, С.Намидын нэрэмжит “Номын амт” утга зохиолын бага наадамд оролцож 2-3,4-5 насны ангилаллаар 650 гаруй хүүхэд оролцлоо.Д.Нацагдоржийн мэндэлсний 110 жилийн ойг тохиолдуулан түүний намтар уран бүтээлийг сурталчлах, түүний номоор үзэсгэлэн гаргалаа.Аймгийн төв номын сангаас 12-	100

		р ангийн сурагчдын дунд зарласан илтгэлийн уралдаанд нийт 11 сурагч оролцлоо.	
3.6.Хөдөлмөр эрхлэлт ,нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэх			
31	3.6.1Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.	ХАБЭАхуйн сарын аяныг угтаж 34 төрийн байгууллагаас ХАБЭАхуй хариуцсан ажилтан болон зөвлөлийн судалгаа авахад 7 байгууллага ХАБ-ын ажилтантай, 13 байгууллага ХАБЭА хариуцсан зөвлөлтэй, 8 байгууллага үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэдэг байнгын комисстой, нийт судалгаа ирүүлсэн байгууллагаас ХАБЭА-н урт, богино хугацааны сургалтанд 28 ажилтан хамрагдсан гэсэн тоон мэдээтэй байлаа. ХАБ-ын ажилтан, зөвлөлгүй байгууллагуудад шаардлага хүргүүлэ, 21 байгууллага ХАБЭА-н ажилтан, орон тооны бус зөвлөлтэй боллоо.	100
32	3.6.2Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийн бүртгэлийг төгөлдөржүүлж Ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучилж ажилгүйдлыг бууруулна.	Шинээр байгуулагдсан “ТЭС ПЕТРОЛИУМ” шатахуун түгээх газар, “Дэлгэрхангай плаза” үйлчилгээний төв, “Өндөр ээж” зоогийн газар зэрэг аж ахуй нэгжүүдийг LMIS программд ажил олгогчоор бүртгэн, 39 ажилчдыг ажилтнаар бүртгэлээ. Гурвансайхан сумын нутагт үйл ажиллагаа явуулж байсан “ЖИ ПИ ЭФ” ХХКомпаний шалгаруулалтад тэнцсэн 4 жолооч, 3 засварчин, 3 туслах ажилтанг, Баянжаргалан сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “ТАЙШЭН ДЕВЕЛОПМЕНТ” ХХКомпани ярилцлагад оролцсон 20-иод иргэдээс тэнцсэн 5 жолооч, 2 туслах ажилтанг, Хөшигтийн хөндийн бүтээн байгуулалтын ажилд 4 жолоочийг тус тус зуучилж Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа “Энержи ресурс” компаниас хүнд даацын машины жолоочийн захиалгын дагуу бүртгэлтэй Е ангилалтай 8 жолооч ярилцлагад бүртгүүлээ. Байнгын ажлын байрны захиалга ирүүлсэн Алтан говь буудал, Сод монгол ШТГазар, Цагаан суварга жуулчны бааз, Галтай зэт ХХК, Бүрд зоогийн газар, Дашваанжил газ түгээгүүрийн газар, Хишиг өгөөмөр ХХК, Мандал зоос капитал, Ижий бараат ХХК, Мандалговь хүнс, МНЧ эмийн сан, Нандин караоке, Их газрын чулуу БЦГ-ын захиргаа, Нэгдсэн эмнэлэг зэрэг газруудын ажлын байрны захиалгыг 150 гаруй иргэнд санал болгож, бүртгэлтэй иргэдээс 10 гаруй иргэн ажилд орж зуучлагдлаа. Ажил идэвхитэй хайж байгаа сар бүр тогтмол бүртгүүлдэг зорилтот бүлгийн 40 гаруй иргэн байна. Эдгээр иргэдэд ганцаарчлан болон хэсэг бүлгээр зөвлөгөө өгч нийтийг хамарсан ажилд зуучиллаа. Мод усалгааны ажилд 60, нийтийн хогийн цэг орчмын хог цэвэрлэгээний ажилд 30 иргэнийг зуучилж нийтийг хамрсан ажлын хүрээнд нийт 90 иргэнийг ажлын байраар хангалаа. Түр ажлын байрын захиалга “Их онь” ХХК-ний ноосны үйлдвэрт 15, нисэхийн нислэгийн талбайн зэрлэг зулгаах ажилд 5, ШШАлбаны газар шорооны ажилд 3, хувь хүмүүсээс захиалга ирүүлсний дагуу барилгын туслах ажилд 6, нүүрс, мод савлах ажилд 7, малын тарилга хийхэд туслах ажилд 3, “Ногоон ази” ТББ-ын мод тарих талбайд ажиллах 15, сумын ЗДТГ-ын цайны газарт 2, Ниливер сервис компаний сендвичен барилгын ажилд 2 иргэдийг зуучлан ажиллууллаа.	100
33	3.6.3Цөөн малтай залуучуудыг малжуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн тогтоолын дагуу тус суманд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтээр цөөн малтай хөдөөгийн 3 багийн 8 залуу малчин өрхийг хамруулж нийт 35 сая төгрөгийн 742 толгой мал олголоо.	100
34	3.6.4Иргэдэд хөдөлмөр эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтуудыг оновчтой хэлбэрээр зохион	Ажил идэвхитэй хайж байгаа, болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдээс өөрсдийн сонирхолын дагуу Зөөгч бармений сургалтанд 25, зочид буудлын өрөөний үйлчлэгчийн сургалтанд 16, худалдагч, касс, няравын сургалтанд 25 иргэнийг тус тус хамруулж сертификат олголоо.	100

	байгуулж мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ.	Үс засах үйл ажиллагаа явуулж байгаа 24 үсчинг давтан сургалтанд хамруулж хувиараа хөдөлмөр эрхлэгч 21, малчин 6, зөвлөх малчин 2 иргэнийг Аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрууллаа.	
35	3.6.6.ХХЭрхлэх хүсэлтэй, санхүүгийн дэмжлэг шаардлагатай иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулан, ШАБайр бий болгоно	Хувиараа хөдөлмөр эрхлэгч 21 иргэнийг санхүүгийн дэмжлэгт хамруулж 51,0 сая төгрөгийн зээл олгож, ажлын байрыг нэмэгдүүллээ. Эдгээр иргэдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавилаа.	100
36	3.6.7.Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийг хэрэгжилтийг бүх шатанд хангаж ажиллана.	Байгууллагууд хуулийн дагуу харъяалалтай ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэн нийт 135 байгууллага, ААНэгж 1577 ахмадыг хүлээн авч 60.6 сая төгрөг зарцуулсан байна. Ахмадууддаа тусалъя аяныг зохион байгуулж 35 байгууллага, ААНэгж 35 ахмадын хашааг тохижуулан хүнс тэжээл, сэтгэл санааны дэмжлэг үзүүлж 14.2 сая төгрөг зарцууллаа. Ахмад настны хуулийн дагуу 435 ахмадад 65,118,8 мянган төгрөгийн хөнгөлөлт тусламж олголоо.Үүнд: Ахмадын зориулалттай амралт сувилалд 280 ахмад амрааж 52,8 сая, Ахмадын бусад хөнгөлөлт тусламжид 327 ахмадыг хамруулж 37,6 сая төгрөгийн хөнгөлөлтийг тус тус олгосон байна.	100
37	3.6.8.Алдар цолтой ахмадуудын гавъяа зүтгэлийг үнэлж хүндэтгэл үзүүлж,алдаршуулна	Монгол цэргийн баярын өдрийг тохиолдуулан сумын засаг даргаас Алдар цолтой ахмадуудад хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа.Сумын Ахмадын зөвлөл ЕБС-ийн 380 сурагчид Эрүүл ахуй-эрүүл амьдрал, Хэв журам сэдвийн хүрээнд уулзалт ярилцлага зохион байгууллаа.	100
38	3.6.9.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	ХБИргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдний өмнө тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцэн эрэмбэлж холбогдох байгууллагуудад хүргэлээ. Мөн суугаа волейбол, шатар, тенисний тэмцээн зохион байгуулж, 50 гаруй ХБИргэд оролцлоо.ОУХЭХамгаалах өдрийг угтаж ХХҮГазар, Дэлхийн зөн ОНХХөтөлбөртэй хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ сонсьё арга хэмжээг зохион байгуулж,хүүхдийн паркт үнэ төлбөргүй тоглуулан 56 хүүхдэд бэлэг гардууллаа. Сумын ХБИргэдийн санал, хүсэлт тэдний өмнө тулгамдаж байгаа асуудлыг хамтран хэлэлцэж ХБИргэдэд чиглэсэн арга хэмжээг сумын хөгжлийн бодлоготой уялдуулан авч хэрэгжүүлэх, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх”-ийн тухай хууль сурталчилах зорилгоор “Хамтдаа шийдье” арга хэмжээг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт сумын удирдлагууд, аймаг,сумын ХБИргэдийн холбооны тэргүүн, баг бүрийн ХБИргэдийн төлөөлөл 62 иргэн оролцлоо. Хөгжлийн бэрхшээлтэй 46 хүүхдийг хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын аймгийн комиссын хурлаар оруулж шинээр 13 хүүхдэд байнгын асаргаа тогтоож, 25 хүүхдийн асаргааг сунгуулж, 4 хүүхдийг ЕБСургуульд хорогдуулсан цагаар суралцах,14 хүүхдэд сэргээн засах үйлчилгээ үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлээ.	100
39	3.6.10.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж,иргэд,ААНэгж,ТББайгууллагатай хамтран ажиллана	Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдаж байгаа 4 өрхийг ОНОТХҮйлчилгээний бүлийн төсөлд хамруулж тус бүр нь 1,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олголоо. Мөн ОНОТХҮ-ий хүрээнд гэрээ бүхий 2 байгууллагын сэргээн засах эмчилгээнд нийт 36 ахмад настан, 8 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулж эрүүл мэндийн үйлчилгээ үзүүллээ НХДТЗШ 5 өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийг ХЭДСангийн ажлын байр дэмжих хөтөлбөрт хамруулж 11,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж өрхийн орлогыг нэмэгдүүллээ.	100
40	Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Сонгогдсон 20 өрхөд аж байдлын дэлгэрэнгүй судалгаа гаргаж, мэдээллийн сан бүрдүүллээ.Хөдөлмөрийн насны ажил эрхэлдэггүй 28 иргэн байлаа. Иргэдийн өөрсдийн хүсэлтийн дагуу 19 иргэнийг ажил хайгчийн бүртгэлд бүртгэн нэн түрүүнд захиалгат ажлын байруудад зуучиллаа. Үүний үр дүнд эмийн сангийн үйлчлэгчээр 1, цайны газрын үйлчлэгчээр 1, уурын зуухны	100

		галчаар 2, нийтийг хамарсан ажил мод усалгааны ажилд 12, хог цэвэрлэгээний ажилд 4 иргэнийг ажиллууллаа. Байнгын болон улирлын чанартай ажилд зуучлагдсан иргэдэд 2580000 төгрөгийн цалинг тухайн байгууллагаас олгож,нийтийг хамарсан ажилд зуучлагдсан иргэдэд ХЭДСангаас 3840000 төгрөгийн санхүүжилтийг зарцууллаа. Ажил хайгч 19 иргэн, ХХЭрхлэгч 8 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө өгч ХХЭрхэлдэг төсөлд хамрагдахыг хүссэн иргэдийн гэрээр явж ажлын байр, ажлын эхлэл, тоног төхөөрөмж зэрэгтэй танилцаж, ОНОТХҮ-ний төсөлд 1 өрхийг дэмжиж 1000000, ХЭДэмжих сангийн төсөлд 2 өрхийг хамруулж 1 өрхөд 3000000 төгрөгийн зээл олгож 1 өрхийг хүнсний ногооны бүлд хамруулан 5000000 төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамрууллаа. Эмнэлэгийн тусламж үйлчилгээ шаардлагатай 3 иргэн өөрсдийн боломжоор ЭМД-д хамрагдаж эмнэлэгийн тусламж үйлчилгээг авлаа. Бага насны 5 хүүхдийг ээлжит вакцинжуулалтад хамруулж эмнэлгийн үйлчилгээ шаардлагатай иргэдэд өрхийн ЭМТөвүүдтэй хамтран тусламж үйлчилгээг хүргэлээ. Зорилтот бүлгийн 6 өрхийн эмэгтэй гишүүнийг эмэгтэйчүүдийн үзлэг, сургалтанд, зорилтот насны 4 эмэгтэйг шинжилгээнд хамрууллаа. Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд зохион байгуулсан сургалт арга хэмжээнд 1 эмэгтэйг хамруулж, үнэ төлбөргүй витамин, төмрийн бэлдмэл зэргийг олголоо. “ Жаргалтай гэр бүл” аяны хүрээнд амьжиргааг дээшлүүлэхээр сонгогдсон 20 өрхөөс 6 өрхийг сонгон 2 сарын хугацаанд зохион байгуулсан олон талд арга хэмжээнд идэвхитэй оролцууллаа.	
41	Зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд чанартай хүргэнэ.	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 191 өрхийн 1033 иргэнийг хамруулж 102,7 сая төгрөгийн хүнсний бараа бүтээгдхүүн олголоо.2017 оны 11 сараас эхлэн Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн шинэчилсэн программын босго оноотой үнэлэгдсэн өрх, иргэдийг хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамруулахаар сонгох ажил хийгдэж байна.2017 оны 11 сарын эхний байдлаар гэр оронгүй болсон 11 хүнд 13,2 сая төгрөгийн дэмжлэг олгоод байна. 2017 оны 10-р сарын байдлаар орон гэргүй иргэдийн судалгааг шинэчлэснээр 35 өрхийн дэлгэрэнгүй бүртгэлийг гаргалаа.	100
42	Сумын нийт өрх, хүн амыг ӨАТТодорхойлох судалгаанд бүрэн хамруулж өрхийн мэдээллийн нэгдсэн санд оруулна.	“Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах ашиглах” журмын 2-р бүлгийн 2,3 дахь заалт, Засгийн газрын хуралдааны 58-р тэмдэглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Орлогыг орлуулан тооцох аргачилалаар Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны ажыг зохион байгуулж нийт 3077 өрхийг хамрууллаа. Судалгаанд хамрагдаагүй болон дахин судалгаанд хамрагдахыг хүссэн 60 гаруй өрхөөс судалгаа авлаа. Амжиргааны түвшин тогтоох судалгаанаас хойш шинээр төрсөн нийт 170 гаруй хүүхдийг өргөдлөөр бүртгэн ӨМНСангийн программ нээгдсэнтэй холбоотойгоор бүх хүүхдүүдийг программд оруулан хүүхдийн мөнгөнд хамрагдах нөхцлийг бүрдүүллээ. Судалгаанд хамрагдаагүй 62 өрхийн өргөдлийг программд заавар журмын дагуу бүртгэн өрх нэг бүрээр орж судалгаанд хамруулах ажлыг зохион байгууллаа. Судалгаатай холбоотой мэдээлэл авахыг хүссэн 500 гаруй иргэнд үнэн зөв мэдээллийг хүргэж шаардлагатай тохиолдолд ХХҮГазарт хандахыг зөвлөлөө.	100
ДӨРӨВ.ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ,ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД			
Зорилго: Уламжлалт мал аж ахуйг фермерийн аж ахуйтай хослуулан хөгжүүлж,бизнес эрхлэгчдээ дэмжин, өрх бүрийн орлогыг нэмэгдүүлнэ			
4.1.Мал Аж ахуй,газар тариаланг хөгжүүлэх			
1	4.1.1 Монгол мал үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлнэ	Сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар тус суманд хэрэгжүүлэх “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэлэлцүүлж, “Төлөвлөгөө батлах тухай” А/74 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.	100

2	4.1.2Залуу малчдаа дэмжих, боловсролыг нь дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Аймгийн Засаг даргын 2017 оны А/46 тоот захирамжаар батлагдсан “Залуу малчдыг дэмжих хөтөлбөр” ийг хэрэгжүүллээ. МСҮТөвд малчны анги нээгдэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас малжуулахад хамрагдсан 3 залуу малчдыг суралцууллаа. Энэ онд төсөл хөтөлбөрүүдэд 18 залуу малчин өрхийг малжуулав.	100
3	4.1.3Малчин залуучуудын зөвлөгөөнийг 2 жилд 1 удаа зохион байгуулна	Тус сумын “Малчин залуучууд”-ын зөвлөгөөнд 100 малчин залуучууд оролцлоо. Малчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээ мэдээлэл өгч урлаг, спортын арга хэмжээг зохион байгууллаа.Зөвлөгөөн нь малчдын залуу халааг бэлтгэх, оролцоог сайжруулах, хашир туршлагатай малчид, мэргэжилтнүүдээс мал аж ахуйн дадлаас суралцаж, залуучуудыг соёл олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулан, нийгмийн идэвхийг сайжруулах ач холбогдолтой байлаа.	100
4	4.1.4Бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг сайжруулан, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж,үр дүнг тооцно.	“Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг батлах тухай” сумын ИТХТэргүүлэгчдийн 04 тоот тогтоол гаргууллаа. Нийт 3 бүлэг 11 заалттай төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүллээ. Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон алт” хөтөлбөрийн Малын эрүүл мэнд- бэлчээрийн төлөв байдал төслийг хэрэгжүүлэх сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдлаа. Хөдөөгийн 4 баг тус бүрт бэлчээр ашиглалтын хэсэг байгуулан ахлагч нарыг сонгон үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. Сургалт сурталчилгаа 2 удаа 311 малчинд хийж, Баяндалай хэсэг 130 гишүүн хуримтлалын сандаа тооцогдох хөрөнгөө төвлөрүүлээд байна. Бэлчээрийг нөхөн сэргээхэд Япон улсын төслөөр 20 сая төгрөг зарцуулан Тэвш багт 2 өрх, Далай багт 3 өрх, Үйзэн багт 6 өрх нийт сумын хэмжээнд 11 өрх 12.5 га бэлчээрийг шинээр хашсан байна. Сумын бэлчээрийн оготоны тархалт нь 97880 га-д байгаагаас 19970 га-д үлийн цагаан оготонотой тэмцэх судалгааг холбогдох газарт хүргүүлж, 2000 га газарт үлийн цагаан оготонотой тэмцэх ажил хийгдэнэ.	100
5	4.1.5.Хөдөөгийн багт жил бүр гүний болон гар худаг засварлах буюу шинээр гаргаж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ	Энэ онд ОНХСангийн 12.0 сая төгрөгөөр хөдөөгийн 4 багт нийт 8 энгийн уурхайн худаг засварлаж, Наран 1, Тэвш 1, Үйзэн 1, Далай багт улсын төсөв оруулалтаар 2 гүн өрмийн худаг нийт 5 худаг шинээр гаргалаа.Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний 3-р бүлгийн 5 заалтын дагуу багуудад 12 энгийн уурхайн худаг, 5 инженерийн хийцтэй худаг гаргасан байна.	100
6	4.1.7.ХААхуйд оруулах хөрөнгө оруулалтыг малчны бүлэг, хоршоонд чиглүүлж, хоршооны гишүүдэд МААхуйн бүтээгдэхүүний урамшууллыг олгох замаар хоршиж ажиллах санал санаачилгыг дэмжинэ.	2016 онд давхардсан тоогоор 1164 өрхийн 39454 арьс ширний материалыг малчин, мал бүхий иргэдээс хүлээн авч холбогдох газарт хүргүүлэн нийт 414 малчин, мал бүхий иргэдийн 83888000 төгрөгийн урамшуулал олгогдлоо. 2018 онд 333 өрхийн 100.9 тн ноосонд урамшуулал олгогдоно.Арьс шир, ноосны урамшуулалд сумын хэмжээнд нийт 8 хоршоогоор дамжуулан оролцсон байна. Мөн малчдын бэлчээр ашиглалтын хэсгийг тус бүр 4 ыг байгуулж дэмжин ажиллалаа.“Ногоон алт” хөтөлбөрийг хэрэгжүүлж,малчдын бүлэг нөхөрлөл нэмэгдэж, хамтын ажиллагаа Баг бүрийн бэлчээр ашиглалтын хэсгээр дамжин үйл ажиллагааг нь эхлүүллээ.	100
7	4.1.9.Мал сүргийн 10-аас доошгүй хувийг индексжүүлсэн даатгалд хамруулах замаар байгалийн эрсдэлээс хамгаална	Энэ онд хөдөөгийн 4 багийн нийт 68 малчин өрх малын индексжүүлсэн даатгалд 7.590.000 төгрөгний даатгал хийлгүүлсэн байна. Багийн Засаг дарга нарын үр дүнгийн гэрээнд малын индексжүүлсэн даатгалд малчдаа хамруулах асуудлыг тусган орууллаа	70
8	4.1.10. “Алтан төлийн эзэн” шалгаруулна.	Алтан төлийн эзнийг шалгарууллаа. Алтан ботго: Үйзэн багийн малчин Маам Түвшинням,Алтан унага:Тэвш багийн малчин Шонхор Отгонбат,Алтан тугал: Үйзэн багийн малчин Хулан Базарваань,Алтан хурга: Тэвш багийн малчин Шатар Мөнхбат,Алтан ишиг: Далай багийн малчин	100

		Дорж Дэлэг нар шалгарлаа.	
9	4.1.13.Нутгийн шилмэл болон гойд ашиг шимт малын өсгөх,сумын брэнд омог,хэвшлийн малтай болох хөтөлбөр боловсруулж батлуулан , хэрэгжүүлнэ	Аймгийн Засаг даргын А/198, сумын Засаг даргын А/129, МЭҮГ-ын даргын А/21 тоот тушаал, ХХААГазрын даргын А/15 тоот тушаалууд, удирдамж гарч “Малд үзлэг, ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх тухай” гэрээний дагуу малд үзлэг, ангилалт хийх ажлыг орон нутагтаа зохион байгууллаа. Хөдөөгийн 16 айлын малд стандартын төвшин тогтоох ажлыг тухайн төрөл, ашиг шимийн чиглэлийн малд ангилалт явуулах зааврын дагуу зохистой хугацаанд монгол болон бусад үүлдэр омог хэвшлийн малд бүгд 2043 хонинд хувьсийн ангилалт хийхэд 321 хээлтэгч цөм сүрэгт, 1469 хээлтэгч үржлийн сүрэгт, 253 хээлтэгч хэрэгцээний сүрэгт хамаарагдлаа.Залуу малчдад мал маллах арга ухаан, малын чанар сайжруулах сургалтанд 11 малчин оролцож Далай багийн малчин Ц.Пүрэвдоржийн хотонд үзүүлэх сургалт зохион байгууллаа. Хөдөөгийн 4 багт ажиллаж таван төрлийн малын амьдын жинг тодорхойлох, нас тус бүрээр таван төрлийн малд хэмжилт хийх, төл малын төрөх үеийн амьдын жинг тодорхойлох, тэмээний ноос, ямааны ноолуурт хяналтын хэмжилт хийх, фенотип шинжилгээгээр үнэлгээ өгөх, туршлагатай малчидтай уулзаж санал солилцох, орон нутгийн хээлтүүлэгчийн стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд дүнэлт өгч танилцлаа. Үүний үр дүнд манай сумын Далай багийн хонь махан ашиг шимээр өндөр улсын Шилмэл малын үзэсгэлэн худалдаанаас гойд ашиг шимт малаар шалгарч байсан. Сумын хонь бусад үүлдэр омгийн малаас ашиг шим дээгүүр фенотип шинжээрээ ялгаатай байсан тул сорилын биологийн хүрээлэнд генетик шинжилгээг хийлгэж бусад үүлдэр омгийн малаас ялгагдах шинж төрхтэй гарлаа.. Нийт 6 өрхөд “Цөм сүргийн эзэн” гэсэн гэрчилгээ олголоо. Малчдадаа хуцан хурга хэрхэн зөв сонгох талаар Монгол улсын зөвлөх мал зүйч Н.Сүхээ /доктор. Ph/ багшаар арга туршлага судлуулан залуу малчдад сургалт зохион байгууллаа. Нийт 193 хуц, 149 ухна суурилагдан зоо, мал эмнэлгийн үйлчилгээнд хамрууллаа. Нийт хээлтүүлэгчийн хуц 23,1%, ухна 19,4% ялгагдсан байна.	100
10	4.1.14 Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж,үр нөлөөг сайжруулж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.	Ирээдүй, Тэвш таван эрдэнэ мал эмнэлгүүд нь шөвөг яр 332 өрхийн 31143 төлд, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг нийт 378 өрхийн 92602 хонь, хурганд /1 ээлж/ 373 өрхийн 49628, /2 ээлж/ 365 өрхийн 48070, сохор догол 4 өрхийн 4000 малд, ДХХ ба энтеробактериоз 54 өрхийн 12431 малд, дуут хавдар 63 өрхийн 1049, сахуу 64 өрхийн 1301 мал, галзуу 12 өрхийн 1000 мал, шүлхий 473 өрхийн 287413 малыг хамруулжээ. Тэвш таван эрдэнэ, Ирээдүй мал эмнэлгийн нэгжүүд нь нийт 20833 мкв талбайг ариутгаж халдваргүйжүүллээ.	100
11	4.1.15Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ,бруцеллёз өвчинтэй тэмцэх арга хэмжээг тогтмол зохион байгуулна.	Тус сумын мал эмнэлгүүд аймаг, сумын засаг даргын “Бруцеллёзын вакцинжуулалт, шинжилгээний ажлыг зохион байгуулах тухай” захирамжийн дагуу тус суманд хуваарилагдсан 88970 малаас 80414 толгой малыг хамрууллаа.	100

12	4.1.16.Өвлийн нарлаг хүлэмжийг байнгын ажиллагаатай болгож, иргэд, байгууллага, ААНэгжийн төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалтыг дэмжинэ.	Өвлийн нарлаг хүлэмж нь 600 мкв талбайд тариалалт хийн эхний ээлжийн ургац хураалтаар 1,2 тн улаан лооль, өргөст хэмхийг хураан авч ААН, иргэдэд нийлүүлж тэдний эрэлт хэрэгцээг хангаад байна. Өвлийн тариалалтын үрсэлгээг 600 м.кв талбайд хийгээд байна. 2017 онд Төмс 9,8 га, хүнсний ногоо 5.02 га, жимс жимсгэнэ 12,4 га нийт 27,2 га талбайд 5 ААНБ, 32 иргэд тариалалт хийсэн нь өмнөх оноос 1 га- гаар нэмэгдсэн байна. Жилийн эцсийн байдлаар 77,3 тн төмс, 43.73 тн хүнсний ногоо хураан авсан нь өмнөх онтой харьцуулахад ургац хураалт нэмэгдсэн үр дүн гарч байна.	100
13	Орон нутагт болон отрын бүсэд байгаа малчдын өвөлжилтийн бэлтгэл ажлыг зохион байгуулна.	Энэ онд сумын аюулгүй нөөцөд 67.2 тн өвс, 31,6 тн тэжээл нөөцлөөд байна. Манай сумын хувьд нийт 745 малчин өрхийн 382043 толгой мал. Үүнээс: /тэмээ 2695, адуу 17986, үхэр 6735, хонь 184728, ямаа 186300/. Нийт малыг хонин толгойд шилжүүлснээр 532069,9 мал өвөлжихөөр 96.8 % тарга хүчийг авсан байна. Малчид өөрсдийн хүчээр 324.7 тн гар тэжээл бэлтгэлээ. Мөн ногооны хаягдал 3.5, давс, хужир шүү 54.7, худалдаж авсан өвс 54.7 тн, тэжээл 27.3 тн байна.	100
4.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнс худалдааны салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх			
14	4.2.2 Хүнсний захыг стандартын дагуу тохижуулж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр иргэдийг хангах боломжийг бүрдүүлнэ.	Тогтох мандал хүнсний зах нь мэргэжлийн малын эмчийг 2016 оны 11 дугаар сараас эхлэн ажиллуулж байна. Сум хөгжүүлэх сангаас Тогтох мандал хүнсний захын гадна талбайн тохижилтонд зориулж 30,0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлийг олгож засварлалаа. “Тогтох мандал” хүнсний захад тогтмол хяналт тавьж байгаа ба 12 сумаас мал эмнэлэг ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээтэй хонины мах 6.1 тн, ямааны мах 1.6 тн, үхрийн мах 150 кг, адууны мах 180 кг, сүү сүүн бүтээгдэхүүн 3.8 тн худалдаалагдсан байна.	100
15	4.2.3. Нийтийн хоол, зочид буудлын үйлчилгээний стандарт, шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавина	Улаанбаатар хот “Түшиг” сургалтын төвтэй хамтран худалдааны болон хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээ эрхлэгч ААНэгж байгууллагын худалдагч тогооч нарын мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг хамтран зохион байгууллаа. Зөөгч бармены сургалтанд 5, худалдагч кассын сургалтанд 3 иргэнийг оролцууллаа. ХХҮГазар, МБС “АС” сургалтын төвтэй хамтран 14 хоног худалдагч, касс, няравын мэргэжил олгох сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд нийт 25 худалдагчид хамрагдаж мэргэжлийн үнэмлэхтэй төгслөө. Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд хоол үйлдвэрлэлийн 14 газар, зочид буудлын үйлчилгээний 3 газарт хоолны газарт тавих шаардлага МНС 4946:2005 стандартын дагуу тохирлын үнэлгээнд хамрууллаа. “Чанартай үйлчилгээ-Эрүүл хүнс” аяныг хүрээнд хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудын үйл ажиллагаатай танилцан зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. “Зочлох үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал” уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж нийт 24 аж ахуй нэгжийн удирдлагууд оролцлоо. “Өэлүн эхийн ачлал” сургалтын байгууллагатай хамтран “Зөөгч бармен зочид буудлын үйлчилгээний ажилтаны мэргэжил олгох 20 хоногийн сургалтыг зохион байгуулж нийт 34 ажилтан хамрагдлаа.	100
16	4.2.5 Хоол, хүнс, үйлдвэрлэл үйлчилгээний ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжинэ.	“Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” уриан дор үндэсний болон орон нутгийн онцлогтой хоол, ундааг сурталчилан таниулж, түгээн дэлгэрүүлэх салбарын ажилтан, ажилчдын ур чадвар, чадамжийг дээшлүүлэх зорилготой говийн бүсийн зөвлөгөөнд /ресторан, баар, кафе цайны газар, эмнэлэг, цэцэрлэг, сургууль/-нд ажиллаж буй 150 гаруй тогооч нар оролцлоо. “Аймгийн аварга тогооч” шалгаруулах ур чадварын уралдааныг зохион байгуулж, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, Хувийн хэвшлийн нийт 34 тогооч 8 номинациар өрсөлдлөө.	100

17	4.2.6.Үйлдвэрлэлээ өргөжүүлэн, бүтээгдэхүүнээ гадаад,дотоодын зах зээлд нийлүүлж байгаа үйлдвэрлэгчдийг дэмжинэ	СХСангаас 9 ААН, 2 бүл 18 иргэнд 567,6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, шинэ ажлын байр 66, түр ажлын байр 16- бий болголоо. Зээлийн үр дүнд барилгын чиглэлээр 2, хоёрдогч түүхий эд ангилах тээвэрлэх, ялгах чиглэлээр 2, мах махан бүтээгдэхүүн малын гаралтай дайвар бүтээгдэхүүн боловсруулах 3, хүнс, нийтийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэл 8, төмөр хийц эдлэл болон тавилгын үйлдвэрлэлээр 4, арьс нэхий элдэх 1, сав баглаа боодол 2, гар урлалын эсгий эдлэлийн жижиг цехын үйлдвэрлэлд 2, гахайн эрчимжсэн аж ахуйд 1, энэ онд нийтдээ шинээр 12 нэр төрлийн 24 үйлдвэр, 3 үйлчилгээг дэмжсэн үр дүн гарч байна. Өмнөх жилүүдэд зээл авсан нийт 134 зээлдэгч нарын зээлийн ашиглалт, зориулалтыг сайжруулах чиглэлээр 3 удаа сургалт, хяналтыг зохион байгуулж хугацаа хэтрэлттэй 88 зээлдэгчээс 9 иргэнийг Шүүхийн эвлэрүүлэн зуучлагчид, 3-г нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, 36 зээлдэгчийн зээлийг бүрэн төлүүлж, 386 155 087 төгрөгийг төвлөрүүлээд байна.	100
18	4.2.7Малын гаралтай түүхий эд мах, махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.	Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлд-3 малын гаралтай түүхий эд арьс шир боловсруулахад -1 нийт 4 үйлдвэрлэлийн төслийг 64.6 сая төгрөгөөр дэмжиж үйлдвэрлэлийн тоог нэмэгдүүллээ. СХСангаас зээл авсан болон хувиараа ЖДҮ эрхлэгч 43 иргэн, хуулийн этгээд “Цагаан сар үзэсгэлэн худалдаа”-нд оролцож, 20 гаруй сая төгрөгийн борлуулалт хийлээ. ХХААХҮйлдвэрийн яамнаас зохионбайгуулдаг Намрын ногоон өдрүүд” арга хэмжээг “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” уриан дор “-Алтан намар 2017” үзэсгэлэн худалдаанд Айраг багийн иргэн Н.Цэцэгмаа 500 граммын 300 ширхэг хүмүүлтэй оролцож 1500000 төгрөгний борлуулалттай ажиллалаа.	100
19	4.2.8Талх, нарийн боовны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангана	Талх нарийн боовны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Өгөөмж цех”, Говийн гэгээ ХХК”-компанид үйл ажиллагаагаа өргөжүүлэх, техник технологийн шинэчлэл, дэвшил гаргах өрсөлдөх чадварын нэмэгдүүлэхэд нь зориулж тус бүр 30 сая төгрөг буюу 60 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож 11 байнгын ажлын байр хадгалагдсан нь ажиллах хүчний тогтвортой байдлыг хангасан үр дүн гарч байна. Талх нарийн боовны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Өгөөмж цех”, Говийн гэгээ ХХК”-компаны менежерүүдийг МҮХАҮТ, ДЗОУБ,АЗДТГ,ХХААГ-тай хамтран зохион байгуулсан үйлдвэрүүдийн туршлага судлах BUS аялалд оролцуулан туршлага судлуулж ажлын байран дээрх сургалтанд хамрууллаа. Мөн өөрсдийнхөө хөрөнгөөр МҮХАҮТ-ын дэргэдэх нарийн боовны сургалтын танхимын сургалтыг орон нутагт авчран ажлын байран дээрх технологийн сургалтыг авч 3-4 нэр төрлийн зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүнийг шинээр гаргасан үр дүнд хүрлээ.	100
20	4.2.10. Шинээр бизнес эрхлэгчдэд төрийн байгууллагаас үзүүлэх мэргэжил,арга зүйн зөвлөгөө өгч чадавхжуулах, бизнесээ хамгаалах сургалтуудыг зохион байгуулна.	Сумын ЖДҮ эрхлэгчдэд “Хамтын ажиллагаа түншлэл” бизнес эрхлэгчдийн сургалтыг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор СЭЗИС-ийн багш нартай, хамтран зохион байгуулж 70, СХСангийн зээлдэгч нарт зориулсан сургалтанд 70, СХСангийн зээлдэгч нарын сургалтыг МҮХАҮТ-ын багш нартай хамтран зохион байгуулж 70, мөн зээл авсан болон авах хүсэлтэй иргэдийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж нийт 230 бизнес эрхлэгчдийг, Аймгийн бизнес эрхлэгчдийн сургалт зөвлөгөөнд 35, Reach төслийн төсөл боловсруулах сургалтанд 20 иргэнийг тус тус хамрууллаа.Хятад улсад болсон 3 улсын үзэсгэлэн худалдаанд тус сумаас 6 иргэн оролцож,бизнесийн хүрээгээ өргөжүүллээ. Шинээр бизнес эрхлэгчдийг нийслэл хотод туршлага судлуулах,бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаанд орон	100

		нутагт болон нийслэлд оролцуулж, орлогыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүллээ.	
21	4.2.12Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ.	Барилгын ханын дүүргэгч материал пенобетон хөнгөн блок үйлдвэрлэх 1 төсөлд 20 сая, барилгын хуурай хольцийн үйдвэрт 40 сая төгрөгийн зээлийг СХСангаас олгоод үйл ажиллагаа нь жигдрээд явж байна. Энэхүү зээлийг олгосноор 6 иргэн байнгын 15 иргэн түр ажлын байраар хангагдлаа. Шинээр бизнес эрхлэгч 20 иргэнийг ОУ-ын хөгжлийн агентлаг ТББ REACH төсөлтэй хамтран сургалтанд хамруулж, тэдний мэдлэгийг сайжруулж өөрсдөөр нь бизнес төлөвлөгөө боловсруулдаг болголоо.	100
22	4.2.13Сав баглаа боодлын үйлдвэрлэлийг бий болгоно	Сав баглаа боодлын чиглэлээр 2 иргэнд 40 сая төгрөгийн төслийг СХСангаас олгож үйл ажиллагаа нь жигдрээд байгальд ээлтэй сав баглаа боодлыг орон нутагтаа үйлдвэрлэдэг боллоо. Энэхүү чиглэлээр төсөл авсан 1 иргэнийг УБ хотын BUS аялалд аялуулан ижил үйлдвэрийн туршлагыг судлуулсан нь тухайн бизнесыг эрхлэхэд улам дөхөм туршлагажсан.	100
23	4.2.14Хөдөлмөрөө хорших,өрхийн үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг дэмжиж,брэнд бүтээгдэхүүн бий болгоно	Хөдөлмөрөө хоршин 2 догч түүхий эдийн үйлчилгээг бий болгох 1 бүл, 1 иргэний бизнес төслийг дэмжин СХСангаас 23 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олголоо. Тухайн бүл, иргэд хөнгөлөлттэй зээл авснаараа 2 догч түүхий эдийг тогтмол авах сүлжээ бий болгон аймгийн төвийн хогийн менежментийг сайжруулахад хувь нэмрээ оруулж сар бүр тушаах тээвэрлэлтийг хийж борлуулалт орлогоо нэмэгдүүлсэн үр дүн гарсан байна.. ДундговьТүншлэл 2017 " түншлэлд сумаас 40 гаруй иргэд, аж ахуй нэгж, өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээрээ оролцлоо.Айраг, ааруул, эзэгий сүү цагаан идээний төрөл, талх нарийн боов, нийтийн хоолны салбарын бүтээгдэхүүн, нутгийн хөрсөнд тарьсан төмс, хүнсний ногоо, мод, модон эдлэл, эсгий, ноосон эдлэл, дээс, хялгасан томмол бүтээгдэхүүн, сур, суран эдлэл, гар урлалын бүтээгдэхүүн гээд олон нэр төрлийн бүтээгдэхүүнийг нэгэн дор төвлөрүүллээ. Энэ жилийн шилдэг бүтээгдэхүүнээр 8 иргэн,ААНэгж шагнагдлаа.	100
24	4.2.15.Иргэдийн санал санаачлага оролцоотойгоор шинээр 6 жижиг дунд үйлдвэр байгуулна	Иргэдийн санал санаачлагад тулгуурлан барилгын материалын 2 түүхий эд ангилах тээвэрлэх, ялгах чиглэлээр 2, мах махан бүтээгдэхүүн малын гаралтай дайвар бүтээгдэхүүн боловсруулах 3, хүнс, нийтийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэл 8, төмөр хийц эдлэл болон тавилгын үйлдвэрлэлээр 4, арьс нэхий элдэх 1, сав баглаа боодол 2, гар урлалын эсгий эдлэлийн жижиг цехын үйлдвэрлэлд 2, гахайн эрчимжсэн аж ахуйд 1, энэ онд нийтдээ шинээр 12 нэр төрлийн 24 үйлдвэр, 3 үйлчилгээг дэмжлээ.	100
25	4.2.16Үйлдвэрлэл ,үйлчилгээ, нөхөрлөл, хоршоо,ЖДҮйлдвэрлэл байгуулах иргэдийн санаачлагыг дэмжин хөнгөлөлттэй зээл олгон, ажлын байрыг нэмэгдүүлж ,ажилгүйдлийн түвшинг 0.2-оос доошгүй хувиар бууруулна.	Бүрэн зост, Арвижих далай, Үйзэн мандал хоршоодод 80,0 сая төгрөгний зээлийн сум хөгжүүлэх сангаас олголоо. Хөдөө Аж Ахуй Хоршоологчдын Холбооны 12-р бага хуралд 15 сумын гишүүн хоршоодын төлөөлөгчид оролцлоо. Үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа “Тогтох мандал ХХК”-д гадна талбай орчноо сайжруулахад нь зориулж 30 сая, нийтийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэхэд зоиулж 120 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 5 ресторан, зоогийн газарт олгосноор тэдгээрийн хоолны чанар үйлчилгээнд ахиц гарах болно.Энэ онд нийтдээ шинээр 12 нэр төрлийн 24 үйлдвэр, 3 үйлчилгээг дэмжсэн үр дүнд шинэ ажлын байр 66 гарсан байна.	100

26	Сум хөгжлийн сангийн үйл ажиллагааг нээлттэй болгож, зээлийн дээд хязгаарыг нэмэгдүүлнэ	Сум хөгжүүлэх сангийн 2017 онд баримтлах тэргүүлэх 21 чиглэлийг ИТХ-аар хэлэлцэн батлуулж сумын сонин, сайт, цахим самбараар зарлан мэдээллээ. СХСангаас 2017 онд 9 ААН, 2 бүл 18 иргэнд 572,6 сая төгрөгийн хөнгөлөлттэй олгосноос зээлийн дээд хязгаар 30-40 сая төгрөгийн зээлийг 11 иргэн, хуулийн этгээдэд олгосон байна. 2017 онд олгосон 14 зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтөд 3 удаагийн хяналт шалгалт хийж хугацаа хэтэрсэн 2011-2016 оны 88 зээлдэгчид мэдэгдэх хуудсыг 2 удаа хүргүүлж өнөөгийн байдлаар 386,155 087 төгрөгийг төвлөрүүлж 2 удаа олголт хийлээ. Энэ онд СХСангийн үйл ажиллагаанд сумын ИХ-ын тэргүүлэгчээр ахлуулсан СХС-н ОТБ хяналтын зөвлөл 1, Аймгийн Аудитын газрын нийцлийн аудитын шалгалт 1, АТГ-ын шалгалтад 1 удаа тус тус амжилттай шалгууллаа. Зээлийн дээд хязгаарыг 30,0 сая төгрөгөөр шийдвэрлэлээ. Сум хөгжүүлэх сангийн 2017 онд баримтлах тэргүүлэх 21 чиглэлийг ИТХ-аар хэлэлцэн батлуулж сумын сонин, сайт, цахим самбараар зарлан мэдээллээ.	100
ТАВ.БАЙГАЛЬ ОРЧИН,ГАЗАР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, УУЛ УУРХАЙН ХҮРЭЭНД <i>Зорилго:Байгалийн нөөцийг зохистой ашиглаж,байгаль хамгаалах,нөхөн сэргээх,аялал жуулчлал,уул уурхайгаас орон нутагт орох орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.</i>			
5.1.Байгаль орчныг хамгаалах			
1	5.1.2Хотын төвд шинээр цэцэрлэгт хүрээлэн байгуулах, өргөтгөн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	Бүх нийтийн мод тарих өдрийн 2016 оны 05-р сарын 13-ны өдөр Сумын ЗДТГазар, Хот тохижуулах газар , Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран “Мандалговь 50” цэцэрлэгт хүрээлэнд 1320 ш хайлаас тариалж арчилгаа усалгааны ажлыг тогтмол хийлээ.Хот тохижуулах газар, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Нийтийг хамарсан ажлаас 40 иргэнтэй хамтран мод усалгааны ажилд 6 сар услуулан 85% ургацтай байна.	100
2	5.1.4Айл өрхөд түлшний хэмнэлттэй, утаа бага ялгаруулдаг, зуухыг хэрэглүүлэх, дэмжих, агаарын бохирдлыг бууруулна.	12 сарын байдлаар насанд хүрсэн 568 иргэн шилжин ирсэн байна. Шилжиж ирсэн өрхийн 90 хувь нь гэр хороололд ирж байна 10 өрхөд дулаан баригч 20.000 төгрөгийн хөнгөлөлттэй үнээр өглөө. Агаарын бохирдол буурах ач холбогдолтой юм.	100
3	5.1.5 Усны нөөцийг тодорхойлох боломжийг судална	Усны тухай хуулийн дагуу усны тоо бүртгэл, байр зүйн зураг, хатуужилтыг судаллаа. Нийт 2020 км зам туулж, худаг-358, булаг-7, тойром-2-ыг тоолж бүртгэлжүүлэн, солбилцол, фото зураг, усны хатуужилтыг судлан судалгааны тайланг хүлээн авлаа.	100
4	5.1.6Ан амьтны тооллогыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, ховор ан амьтны амьдрах орчныг тэтгэх,тарвага нутагшуулах арга хэмжээ авна.	Аймгийн Засаг Даргын Тамгын газар, БОАЖГ, Эко-үйлчилгээТББ-тай хамтран ан агнуурын тооллого зохион байгуулан тайланг хүлээн авч ажиллалаа. Уг тайланд аргаль 16, янгир 7, тарвага 36 ширхэг бүртгэгдээд байна.Далай багийн нутаг дэвсгэрт тарвага нутагшуулан тоо толгойг энэ жил судаллаа. Судалгаагаар тарвага 20, мөндөл 16 ширхэг бүртгэгдлээ.	100
5	5.1.7Байгаль орчныг хамгаалах хяналтын үр дүнг дээшлүүлэн, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Хайрга олборлож байсан аж ахуй нэгжийг хяналт шалгалтаар илрүүлж таслан зогсоож, нөхөн төлбөр 400.0 төгрөгийг байгаль хамгаалах санд төвлөрүүллээ. Мөн Аймгийн мэргэжлийн хяналтын газартай хамтран ШТСтанцын 5 газрыг шалгаж зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Далай багийн нутаг дэвсгэрт байрлах Авдрантын хүнхэр гэх газар булш хэрэгсүүр ухсан хэргийн дуудлагаар Аймгийн цагдаагийн хэлтэс, Шүүх шинжилгээний алба, багийн даргын хамт дуудлагаар очиж хэрэг үүсгэн Цагдаагийн газарт шалгалтын ажил хийгдэж байна .	70

6	5.1.8 Малчдын эзэмшиж байгаа өвөлжөө, хаваржааны доорх газрыг гэрчилгээжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Засаг даргын 8 удаагийн захирамжаар өвөлжөө, хаваржааны доорх газраа эзэмших хүсэлт гаргасан 38 малчин иргэнд 19,0 га газрыг эзэмшүүлж, гэрчилгээ олголоо. Үүнд Наран багийн 12, Тэвш багийн 2, Далай багийн 12, Үйзэн багийн 12 нийт 38 малчин иргэнд 19,0 га газрыг эзэмшүүлж, гэрчилгээ олголоо.	100
7	5.1.9. Сумын газар зохион байгуулалтыг сайжруулж, иргэдийн хүсэлтийн дагуу иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ	2016 оны 12-р сарын 17-ны өдрийн ИТХ-ын хуралдаанаар 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцүүлж, батлууллаа. Иргэдээс газар өмчлөхийг хүссэн 1600 өргөдөл хүлээн авснаас аймгийн засаг даргын 7 удаагийн захирамжаар 1309 иргэнд 111,9 га газрыг хуулийн дагуу үнэгүйгээр өмчлүүллээ. Үүнээс 20 иргэнд одоо эзэмшиж байгаа хашааных нь 1,7 га газрыг өмчлүүлсэн байна.	70
8	5.1.10. Иргэн аж ахуй нэгж байгууллагад газрыг эзэмшүүлж, эзэмшил газрын ашиглалтыг сайжруулна.	5 иргэн, 3 ахуйн нэгжид 633,7 га газрыг үйлдвэрлэл, үйлчилгээ, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлж, ашиглууллаа. Үүнд үйлчилгээний зориулалтаар 3 иргэнд 0,21га, үйлдвэрлэл, технологийн зориулалтаар 2 ААН-д 628,9га, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 1 иргэнд 0,07 га, туслах аж ахуй эрхлэх зориулалтаар 1 иргэнд 0,09га газрыг эзэмшүүлж, 1 иргэнд 0,015га, 1 ААН-д 4,5 га газрыг цахилгаан памжуулах агаарын шугам барих зориулалтаар тус тус ашиглууллаа. Шинээр газар өмчлөхийг хүссэн 1309 иргэний өргөдлийг газрын мэдээллийн сангийн ЛМ-2 программд бүртгэж аймгийн ГХБХБГазарт шилжүүллээ. Газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч нарт газрын төлбөр татвар ногдуулснаас төлбөрийн гүйцэтгэл 4,230 сая төгрөг буюу 94%-тай байна.	100
9	5.1.11 Хотын хогийн нэгдсэн цэгийг шуух, хашаажуулах ажлыг зохион байгуулж, байгаль орчны бохирдлыг багасгана	Засаг даргын захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллаж, нэгдсэн хогийн цэгийг шуух ажлыг дуусгалаа. ОНХСангийн 50сая төгрөгний санхүүжилтээр хийгдсэн хогийн шинэ цэгийг хашиж, хог булшлах 60*60*5 харьцаатай нүх ухах ажлын зураг төсвийг хийлгэж, ажлын явц, гүйцэтгэл, чанарт хяналт тавьж ашиглалтанд хүлээж авлаа. ХХГазраас тус бүр 10 хүнтэй 3 ээлжийн буюу 30 иргэнээр хогийн талбайн гадна орчны 360 га талбайд тархсан их хэмжээний хогийг цэвэрлүүлэх ажлыг зохион байгууллаа. Шинээр байгуулсан хогийн нэгдсэн цэгийн ашиглалтын байдалд 3 хоног тутамд хяналт тавилаа.	100
5.2. Аялал жуулчлалыг дэмжих			
10	5.2.2. Жуулчны бааз байгуулан ажиллаж байгаа иргэдтэй хамтран ажиллана.	“Рашаантын ам” эко амралтын газрын барилгын ажил 95% тай явагдаж байна. “Сүлд морь” ХХК амралтын газар тэтгэврийн насны иргэдийг хямдралтай үнээр авч амруулж, “Ачлал оргил” амралтын газар сум хөгжлийн сангаас зээл авч үйл ажиллагаагаа явуулж, сумын зохион байгуулсан ажилтай хамтран ажилладаг. “Рашаантын ам” эко амралтын газар нь одоогийн байдлаар манаач, малчин 1, “Сүлд морь” ХХК амралтын газар нь 4, “Ачлал оргил” амралтын газар 1 иргэнийг цалинжуулан ажиллуулна.	100
5.3. Ашигт малтмал, уул уурхайн хяналтыг сайжруулах			
11	5.3.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэнд тавих хяналтын үр дүнг дээшлүүлнэ.	Тэвшийн говийн нүүрсний уурхайн 2016 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнэн төлөвлөгөөт хяналт шалгалтыг Байгаль орчин аялал жуулчлалын газар, МХГазартай хамтран хийлээ. Шалгалтаар бага эрсдэлтэй гэж үнэлэгдэн цаашид анхаарч ажиллах талаар зөвлөгөө өглөө. Тэвшийн говь ХХК-ний нүүрсний уурхайн иргэдэд нээлттэй цахим хаягтай болгох ажлыг зохион байгууллаа.	70

12	5.3.2Сумын нутаг дэвсгэрт байгаа элс, хайрга олборлолтын хяналтыг сайжруулж, татварын орлогыг бүрдүүлэхэд анхаарч ажиллана	Түгээмэл тархацтай байгалийн баялгийн гэрээг ААНэгж, иргэдтэй байгуулан, орлого төвлөрүүлэхэд анхаарч ажиллалаа. Одоогийн байдлаар 11.920.500 төгрөг төвлөрөөд байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтэнд долоо хоногт 3 удаа эргүүл хяналтыг хийж ажиллаж байна.	70
ЗУРГАА. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД			
Зорилго: Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтыг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлан нэмэгдүүлж, бүтээн байгуулалтыг өрнүүлнэ.			
6.1. Дэд бүтцийг сайжруулах			
1	6.1.1. Аймгийн төвд 35 мвт хүчин чадалтай дулааны станц, 4 км шугам хоолой, дулаан дамжуулах төвийн барилгыг барьж, айл өрх, байгууллагуудыг хэрэглээний халуун усаар хангана.	Хийгдээгүй Үнэлэх боломжгүй	-
2	6.1.2. Гэр хорооллын 0,4 кв-ын цахилгааны шугамыг төмөр бетон тулгуур, бүрээстэй утсаар сольж, ухаалаг тоолуурын систем нэвтрүүлнэ.	Боржигон багт Малчин гэр хорооллын 128 айлын цахилгаан хангамжийг сайжруулах ажлыг “Мон Энержи корпораци” ХХК 38.900.000 –өөр хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өглөө.	100
3	6.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зорчих замыг нэмэгдүүлнэ	Энэ онд Найрамдлын гудамжны зүүн талд, тагнуулын газрын урд тус тус баригдсан 12,16 айлын 3 орон сууц шинээр баригдаж ашиглалтанд орлоо. Эдгээр газруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан шат, бариултай хашлага зэргийг хийх үүрэг өгч хэрэгжүүллээ.	70
4	6.1.7. Малчны хороолол бий болгож, мал бүхий болон туслах аж ахуйтай өрхийг хотын төвөөс гадагш гарган төвлөрүүлэх, дэд бүтцийг шийдвэрлэнэ.	2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж ИТХ-аар батлууллаа. Наран багт малчдыг төвлөрүүлэхээр 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, сумын ИТХ-аар батлуулан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэхийг хүссэн иргэдэд төсөл сонгон шалгаруулалтаар гэээр эзэмшүүлэх тухай Засаг даргын 24 тоот захирамжаар зарласан боловч төсөл ирээгүй.	40
6.2. Барилга, хот байгуулалтыг шинээр нэмэгдүүлж, тохижилтыг сайжруулах			
5	6.2.1. Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгыг ашиглалтанд оруулна.	2017 оны төсвийн тодотголоор Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна цахилгааны ажлыг 50 сая төгрөгөөр хийлээ. Тухайн байгууламжийг аймгийн Биеийн тамир спортын газарт хүлээлгэн өглөө.	100
6	6.2.4. Сумын 1-р цэцэрлэгийн барилгыг буулган, шинээр барина	Үнэлэх боломжгүй	-
7	6.2.5. Сумын ЗДТГазрын барилгыг шинээр барина	Үнэлэх боломжгүй	-
8	6.2.6. Зарим сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгад засвар хийнэ.	ЭДЦСургуулийн дотуур байрны дээврийг аймгийн ОНХСангийн 57.3 сая төгрөгөөр, 5-р цэцэрлэгийн их засварыг “Өвсний үндэс”-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн 146,067,033 төгрөгөөр гүйцэтгэлээ. ЭДЦСургуулийн дотуур байрны сантехникийн засварын зураг, төсвийг хийж холбогдох газарт	100

		хандаад байна.	
9	6.2.10 Замын сангийн хөрөнгөөр аймгийн төвд шинээр зам барих, засварлах, явган хүний зам талбай байгуулна.	Замын сангийн 2000.0 төгрөгийн хөрөнгөөр “Их логийн говь” ХХКомпани Чагдаржавын талбайг тойрсон таван босоо тэмдэг, Говийн Ирээдүй цогцолбор сургуулийн баруун талын авто замд 1, 4, 6-р цэцэрлэгийн хойд замд 2, Мандал сургуулийн зүүн талын замд 1 нийт 4 хурд сааруулагч хийлээ. Замын сангийн 52.859.549 төгрөгөөр “Их логийн говь” ХХКомпани аймгийн төвийнХудалдааны гудамж, Сургуулийн гудамж, Найрамдлын гудамж ,Бага тойруу, Буяннэмэхийн өргөн чөлөө,Залуучуудын гудамжны замуудын эвдрэлд нөхөөс хийж засварлалаа.	100
10	6.2.11Гэр хорооллын гудамжнуудыг цэгцлэх, хөндлөн гарц гаргаж, хашааг жигдрүүлэх, тохижуулах арга хэмжээг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ	Цагдаагийн газартай хамтран Гадна тохижилт-Аюулгүй орчин болзолт уралдаанд Тогоогийн говь ХХК, Ялгуум билэгт ХХК, ХХҮГ тус тус шалгарлаа. Төсөвт байгууллагуудын дунд “Ахмадууддаа тусалъя” уриалгыг өрнүүлэн 34 байгууллага, ААНэгжүүд 34 ахмад настанд 14.0 сая төгрөгийн тохижилт , дэмжлэг туслалцаа үзүүллээ.	40
11	6.2.12.Гэрэлтэй Мандалговь”, .”Ногоон Мандалговь” Шинэ гудамж” төслүүдийг хэрэгжүүлнэ.	Буян нэмэхийн өргөн чөлөө, Залуучууд, Бага тойруу, Сургуулийн гудамжны 126 ширхэг лед гэрэлтүүлэгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх 120 вт –ын 126 ш лед толгойг “Хая Тэк” ХХКомпани 23.500.000 –өөр нийлүүлээ. Хүүхдийн паркаас МТ ШТС хүртэл улсын чанартай зам дагуу 65 ш тулгуур шон бүхий гэрэлтүүлэг хийх ажлыг Эрчим сансар ХККомпани 176.411.651 төгрөгөөр хийж гүйцэтгэлээ. Буяннэмэхийн өргөн чөлөөний замын хоёр талаар нийт 1400 ш хайлаасны суулгацыг суулгаж усалгаа, арчилгааг хийж байна. Ургалт 95% байна.	100
12	Төвийн орон сууцны хэрэглэгчдийн дулааны гадна болон дотор шугам сүлжээг үе шаттай шинэчилнэ.	Үнэлэх боломжгүй	-

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН: ЗДТГАЗРЫН ДАРГА

Б.ОЮУНЧИМЭГ

ХЯНАСАН :ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГТОХ